



НЭЭЛТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



**ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР ДАХЬ
ГАРААНЫ БИЗНЕСИМ ПОРТЫН НЭМЭГДСЭН
ӨРТГИЙН АЛБАН ТАТВАР НОГДУУЛАЛТЫГ
БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ БОЛОМЖ**

Улаанбаатар
2024 он



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР ДАХЬ ГАРААНЫ БИЗНЕСТ ИМПОРТЫН НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАР НОГДУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ БОЛОМЖ

Д.Нарантуяа (Ph.D) дэд профессор
Д.Лхамжав (LLM)
Д.Дайриймаа (MBA)

Улаанбаатар
2024 он

ТАЛАРХАЛ

Цаг үеийн тулгамдсан асуудлыг хөндөн хэлэлцэх завшаан тохиогоогүй бол энэхүү судалгааны ажлыг гүйцээх боломжгүй байлаа. Тиймээс юуны өмнө ярилцлагад оролцсон жижиг, дунд бизнес эрхлэгчид болон судалгааны шинэ байгууллага гэж чамлалгүйгээр итгэл хүлээлгэж, судалгаа хийх боломж, нөхцөлөөр хангасан Нээлттэй Нийгэм Форумын нөхдөдөө гүн талархал илэрхийлье. Түүнчлэн хэрэгтэй газраас зорьсон хүмүүсээ олоход тусалсан нийслэлийн “Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төв” НӨҮГ, “Хөгжлийн шийдэл” ТББ-д их баярлалаа. Нийгэм, эдийн засгийн цаг үеийн тулгамдсан асуудлын шийдлийг хамт хайж, дэмжиж ажиллаж байгаа та бүхэнд чин сэтгэлээсээ талархаж байна.

Хараат бус судалгааны “Арвис төв” ГҮТББ
Харилцах хаяг: arviscenter@gmail.com

АГУУЛГА

| | |
|---|----|
| ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ | 5 |
| ӨМНӨХ ҮГ | 6 |
| ХУРААНГУЙ..... | 7 |
| УДИРТГАЛ | 8 |
| Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч | 8 |
| Гарааны бизнес | 9 |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар..... | 10 |
| Судалгааны зорилго ба судлах асуудал | 12 |
| СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ | 13 |
| ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР ДАХЬ ГАРААНЫ БИЗНЕСТ НОГДУУЛЖ БҮЙ ИМПОРТЫН НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ | 14 |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн босго | 15 |
| НӨАТ ногдуулалт, хувь хэмжээ | 19 |
| Импортын нэмэгдсэн өртгийн албан татвар ба бүртгэл | 22 |
| Импортын нэмэгдсэн өртгийн албан татварын ногдол ба жижиг, дунд үйлдвэрлэл | 23 |
| ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛД НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ДАРАМТ ҮҮСГЭЖ БҮЙ АСУУДЛУУД | 25 |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөлтийн дутмагшил | 25 |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар хэрэгжүүлэлтийн дутмагшил | 27 |
| НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАР ТӨЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙН ДУТМАГШЛААС ҮҮСЭХ ҮР ДАГАВАР..... | 30 |
| Үйлдвэрлэл “нарийнтах” өвчин ба чанаргүй амьжиргаа..... | 30 |
| Бараа, түүхий эдийн чанарын асуудал | 30 |
| Үйлдвэрлэл “нарийнтах” | 31 |
| НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ДАРАМТЫГ ХӨНГӨРҮҮЛЭХ ЗАРИМ ШИЙДЭЛ | 35 |
| ДҮГНЭЛТ | 36 |
| САНАЛ, ЗӨВЛӨМЖ | 37 |
| НОМ ЗҮЙ..... | 38 |
| Монгол эх сурвалж | 38 |
| Гадаад эх сурвалж | 39 |
| ХАВСРАЛТ А. Фокус бүлгийн уулзалтад оролцогчийн бүртгэл, асуулт..... | 40 |
| ХАВСРАЛТ Б. Фокус бүлгийн уулзалтад оролцогчдын үйл ажиллагааны чиглэл..... | 41 |

ХҮСНЭГТ

| | |
|---|----|
| Хүснэгт 1. ЖДҮ эрхлэгчийн ангилал | 9 |
| Хүснэгт 2. НӨАТ суутган төлөгчийн босго ба ЖДҮ, үйлчилгээ эрхлэгч | 16 |
| Хүснэгт 3. НӨАТ төлөгчийн босго | 18 |
| Хүснэгт 4. Зарим улсын НӨАТ-ын хувь, хэмжээ | 19 |

ГРАФИК

| | |
|--|----|
| График 1. Нэгдсэн төсөв дэх татварын орлого ба НӨАТ-ын орлогын бүтэц | 14 |
| График 2. НӨАТ-ын бүтэц, 2021, 2022 он | 15 |

ШИГТГЭЭ

| | |
|---|----|
| Шигтгээ 1. НӨАТ суутган төлөгчийн босго | 17 |
| Шигтгээ 2. (а, б, в). НӨАТ ногдуулалт, хувь, хэмжээний тухайд | 20 |
| Шигтгээ 3. Бичил экспорт | 22 |
| Шигтгээ 4. ЖДҮ эрхлэгчийн эргэцүүлэл | 22 |
| Шигтгээ 5 (а, б, в, г). НӨАТ төлөлтийн дутмагшил | 26 |
| Шигтгээ 6 (а, б, в). НӨАТ хэрэгжүүлэлтийн дутмагшил | 27 |
| Шигтгээ 7 (а, б, в). Бараа, түүхий эдийн чанарын асуудал | 30 |
| Шигтгээ 8 (а, б, в, г). Үйлдвэрлэл “нарийнтах” асуудал | 33 |
| Шигтгээ 9. Зарим шийдэл | 35 |

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|--|--------|
| Аж ахуйн нэгж | ААН |
| Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар | ААНОАТ |
| Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем | БТКУС |
| Жижиг, дунд үйлдвэрлэл | ЖДҮ |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар | НӨАТ |
| Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар | НӨҮГ |
| Олон улсын хөдөлмөрийн байгууллага | ОУХБ |
| Төрийн бус байгууллага | ТББ |
| Улсын Их Хурал | УИХ |
| Үндэсний статистикийн хороо | ҮСХ |
| Хөдөө аж ахуй | ХАА |
| Хувь хүний орлогын албан татвар | ХХОАТ |
| Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллага | ЭЗХАХБ |

ӨМНӨХ ҮГ

Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь ядуурал, ажилгүйдлийг бууруулахын зэрэгцээ эдийн засгийн өсөлтөд чухал үүргийг гүйцэтгэдэг хэмээн олон улсад үздэг. Иймд Нээлттэй Нийгэм Форумын захиалгаар “Хараат бус судалгааны арвис төв” ТББ-ын судалгааны баг жижиг, дунд үйлдвэрлэлд нэмэгдсэн өртгийн албан татвар болон импортын нэмэгдсэн өртгийн албан татварын үзүүлж буй ачаалал болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга замын талаар судалж, уг татварын ногдуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр зөвлөмж гаргасныг сонирхогч талуудад хүргэж байна.

Судалгааны дүнд үндэслэн судлаачдын зүгээс бодлого боловсруулагчдад хандан гаргасан санал, зөвлөмжөөс дурдвал, нэмэгдсэн өртгийн албан татварын босгыг өөрчлөх, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч нарын нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулалт, тайлагналыг хялбаршуулж, мөнгөн сууриар төлдөг болох эрх зүйн орчныг бүрдүүлэх, татварын нэгдсэн мэдээллийн сан болон гаалийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл харилцан солилцох нөхцөлийг бүрдүүлж, бараа, ажил, үйлчилгээг бүртгэх олон улсын стандартын шаардлага хангасан зураасан кодыг нэвтрүүлэх зэрэг байна.

Нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулалтыг боловсронгуй болгох асуудлаар олон нийтийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэхэд энэхүү судалгаа чухал хувь нэмэр оруулна хэмээн найдаж байна.

Судалгааг хийж гүйцэтгэсэн доктор Д.Нарантуяа, Д.Лхамжав, Д.Дайриймаа, судалгааны тайланг сайжруулахад үнэтэй санал, шүүмж өгч ажилласан хөндлөнгийн шинжээч С.Батчимэг, Нээлттэй Нийгэм Форумын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам нарт талархал илэрхийлье.

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал

ХУРААНГУЙ

Жижиг, дунд үйлдвэрлэлийн салбар дахь гарааны бизнест ногдуулж буй импортын нэмэгдсэн өртгийн албан татварын өнөөгийн байдал, энэхүү татвар ногдуулалтыг боловсронгуй болгох боломж, хэрэгцээг тодорхойлох зорилгоор бид нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) төлөгчөөр бүртгэх босгыг тодорхойлж, жижиг, дунд үйлдвэрлэл дэх НӨАТ ба импортын НӨАТ-ын ачаалал болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга замын талаар хөндөж судаллаа. Энэхүү судалгааг Үндэсний статистикийн хороо (ҮСХ) болон Татварын ерөнхий газрын тоон мэдээлэл, Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжид эрх зүйн байх ёстой хэм хэмжээ буюу позитив онолын эмперик болон логик арга зүйгээр хийсэн дүн шинжилгээ, хоёр фокус бүлгийн ярилцлагын мэдээллийн шинжилгээнд суурилан гүйцэтгэв. Судалгаагаар импортын НӨАТ төлөлтийн болон хэрэгжүүлэлтийн дутмагшил байгаа нь илэрсэн ба түүнээс гарсан үр дагаврыг тодорхойлж, холбогдох санал, зөвлөмжийг гаргалаа. Мөн НӨАТ төлөгчийн 50 сая төгрөгийн босго нь бичил бизнест ачаалал үүсгэдэггүй, харин ч жижиг, дунд бизнесийн хувьд хэт доогуур буюу зохистой хэмжээнээс 4 дахин доогуур болохыг тооцооллоо.

УДИРТГАЛ

Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч

Жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ) эрхлэгчийг олон улсын байгууллага болоод дэлхийн улс орнууд өөр өөрийн онцлогт нийцүүлэн тодорхойлсон байдаг. Нэгдсэн тодорхойлолт үгүй боловч тэдгээр нь ажиллах хүчний тоо, нийт хөрөнгө, жилийн нийт борлуулалтын орлогыг харгалздагаараа нийтлэг.

Олон улсад тухайн бизнесийг жижиг, дунд үйлдвэрлэлийн ангилалд оруулахын тулд дараах болзлуудаас ядаж хоёрыг нь хангасан байх ёстой гэж үздэг¹. Үүнд:

- Тухайн бизнесийн удирдлага бие даасан буюу үйл ажиллагааг өөрөө эрхлэн явуулдаг;
- Хөрөнгө оруулалт ба өмч нь ганц эсвэл хэдхэн тооны хүний мэдлийнх байдаг;
- Бүтээгдэхүүн борлуулах зах зээл нь тухайн бизнесийн үндсэн байршил болох орон нутагт эсвэл өөр газар ч байх боломжтой байдаг;
- Бизнесийн цар хүрээ, салбар дахь өрсөлдөгчдөөс жижиг байх зэрэг орно.

Монгол Улсын Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль²-ийн 3.2, 4.1.1 дэх заалтыг үндэслэн 200 хүртэл ажилтантай, жилийн 2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж (ААН)-ийг “жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч” гэж тодорхойлсон байдаг. Манай улс ийнхүү ажилчдын тоо, жилийн борлуулалтын орлогоор тодорхойлсон бол Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ) үүн дээр нийт хөрөнгийг нэмж тодорхойлжээ³. Харин өндөр орлоготой Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-ын орнууд жилийн борлуулалтын орлого болон хөрөнгөөр ангилахын аль алийг нь дэмждэггүй⁴.

ЖДҮ эрхлэгчийг үйл ажиллагааны цар хүрээнээс хамаарч бичил, жижиг, дунд гэж ангилдаг (Хүснэгт 1).

1 Mary Jane Byrd, Small Business Management An Entrepreneur's Guidebook, 8th edition, McGraw-Hill, NY, 2017, page 8.

2 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2019, №29

3 ILO, Small Matters, GE, 2019. page 5. https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---dgreports/---dcomm/---publ/documents/publication/wcms_723282.pdf

4 OECD, Entrepreneurship at a Glance, PR., 2017, page 13. entrepreneur_aag-2017-en.pdf (oecd-ilibrary.org)

Хүснэгт 1. ЖДҮ эрхлэгчийн ангилал

| | | Ажилтны тоо | Жилийн нийт борлуулалт | Нийт хөрөнгө |
|-------|--------|-------------|-------------------------|--------------------|
| Бичил | ОУХБ | <10 | < \$100,000 | < \$100,000 |
| | Монгол | <10 | 300.0 сая ₮ хүртэл | - |
| | ЭЗХАХБ | <10 | - | - |
| Жижиг | ОУХБ | 10<50 | \$100,000< \$3 сая | \$100,000< \$3 сая |
| | Монгол | 10<50 | 300.0 сая ₮<1 тэрбум ₮ | - |
| | ЭЗХАХБ | 10<49 | - | - |
| Дунд | ОУХБ | 50<300 | \$3 сая< \$15 сая | \$3 сая < \$15 сая |
| | Монгол | 50<200 | 1 тэрбум ₮<2.5 тэрбум ₮ | - |
| | ЭЗХАХБ | 50<249 | - | - |

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

Гарааны бизнес

Том компанийн жижиг хувилбарыг гарааны бизнес мэтээр ойлгох нь түгээмэл. Гарааны бизнест шинэ бизнес орохоос гадна нэгэнт үүсгэн байгуулагдсан компанийн нэгж, хэлтэс ч орох нь бий. Гэсэн хэдий ч тухайн бизнесийн бүтээгдэхүүн, үйлчилгээний онцлогоос хамаарч гарааны бизнесийн амьдралын мөчлөг, тэсэж үлдэх хугацаа харилцан адилгүй байдаг. Зах зээлд зарим гарааны бизнес бүтээгдэхүүнээ хөгжүүлэхэд ихээхэн цаг хугацаа, хүч хөдөлмөр зарцуулж байхад, нөгөө хэсэг нь бий болгосон үйлчилгээгээ хэрэглэгчдээр хүлээн зөвшөөрүүлэх асуудалтай тулгарч байдаг⁵.

Мэргэжилтнүүдийн гаргасан судалгаагаар гарааны бизнесийн 50 хувь нь 5 жилээс илүү хугацаанд оршин тогтнодоггүй болохыг тогтоосон нь бий⁶. Тухайлбал, гарааны бизнесийн бүтэлгүйтлийн жилийн дундаж түвшин Австралид 9 хувиас давдаг ба 10 жилийн хугацаанд 64 хувь нь үйл ажиллагаагаа явуулах боломжгүй болсон талаар 5196 гарааны бизнес эрхлэгчдийн дунд хийсэн судалгаанд дурдсан байна. Америкийн нэгдсэн улсын төр, хувийн хэвшлийн 8.9 сая өгөгдлийн сан дахь гарааны бизнес эрхлэгчдийн 1998-2005 оны 7 жилийн мэдээлэлд хийсэн судалгаагаар 1998 онд үүсэн байгуулагдсан бүх бизнесийн дөнгөж 44 хувь нь 4 жил тэссэн бол 31 хувь нь л 8 дахь жилтэйгээ золгож, үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулж байжээ⁷.

5 Steve Blank and Bob Dorf, *The Startup Owner's Manual*, TM 2012, pages 52, 18 https://smeportal.unescwa.org/sites/default/files/2019-12/The_Startup_Owner%20s_Manual-A%20step%20by%20step%20guide%20for%20building%20a%20great%20company.pdf?fbclid=IwAR06Rscu4B0QAsF2e7NXjmjSGOLvhiZX-qtMACZh1Xmz3p5kw1b3-OT3e2o

6 <https://www.theguardian.com/small-business-network/2015/jul/23/why-startups-succeed-others-dont-businesses-survive>

7 Aswath Damodaran, *Valuing Young, Start-up and Growth Companies: Estimation Issues and Valuation Challenges*, NY., 2009, page 5. <https://pages.stern.nyu.edu/~adamodar/pdfiles/papers/younggrowth.pdf>

ЭЗХАХБ-аас 2015 онд 16 улсын гарааны бизнес эрхлэгчдийн өгөгдөлд хийсэн харьцуулсан судалгаагаар бизнесийн тэсэж үлдэх боломж үүсэн байгуулагдсанаас хойш 3 жилийн дараа дунджаар 60 хувь, 5 жилийн дараа ойролцоогоор 50 хувь, 7 жилийн дараа 40 гаруй хувьтай байна. Цаашилбал, бизнесээ зогсоох магадлал эхний 2 жилд хамгийн өндөр байдаг ба үүнээс хойш (шугаман байдлаар) буурдаг болох нь олон улс оронд ажиглагджээ⁸.

Дээрхээс үзвэл гарааны бизнес нь тодорхой амьдралын мөчлөгийг туулдаг ба үйл ажиллагаа нь тогтворжиход 7-10 жил шаардагддаг байна. Үүнийг үндэслэн бид гарааны бизнест 10 хүртэл жил оршин тогтнож байгаа хувь хүн, хуулийн этгээдийг судалгаандаа хамруулсан юм.

Нэмэгдсэн өртгийн албан татвар

Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) бол дэлхийн улс орнуудад хамгийн түгээмэл тархсан хэрэглээний татвар билээ. Сонгодог утгаараа НӨАТ нь эцсийн хэрэглээнд ногддог шууд бус татварын төрөлд ордог ба түүнийг үйлдвэрлэлийн үе шат бүр дэх нэмүү өртөг бүрд ногдуулж тооцдог. НӨАТ нь Value added tax гэх англи нэршлээрээ дэлхийд танигдсан хэдий ч зарим улс оронд хэрэглээний татвар, бараа, үйлчилгээний татвар гэж нэрлэгддэг.

Олон улсын валютын сан (ОУВС)-гаас НӨАТ-ын хэрэглээ, түүний давуу талын тухай 2001 онд дараах байдлаар тодорхойлж байжээ. “Дэлхийн хүн амын 70 гаруй хувь болох 4 тэрбум гаруй хүн НӨАТ-ын системтэй улсад амьдарч, 18 их наяд ам.долларын татвар төлж, засгийн газруудын нийт орлогын дөрөвний нэгийг бүрдүүлж байна. НӨАТ нь сүүлийн 10 гаруй жилд маш эрчимтэй дэлгэрч дэлхийн 120 гаруй улсын төсвийн орлогын гол хэрэгсэл болжээ. Анх Европ, Латин Америкийн хөгжилтэй орнуудад өргөн дэлгэрсэн тус систем нь өдгөө шилжилтийн эдийн засаг бүхий улс орнуудын татварын системд голлох үүрэгтэй болжээ⁹.

НӨАТ-ыг дэлхийн II дайны дараагаас нэвтэрч эхэлсэн татвар гэж үздэг. Хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай улс орнуудын төсвийн орлогын голлох хувийг НӨАТ эзлэх нь түгээмэл¹⁰. “Ernst & Young”-аас эрхлэн гаргадаг “Дэлхийн НӨАТ-ын 2023 оны гарын авлага”-д энэ оны 3 дугаар сарын байдлаар дэлхийн 149¹¹ улс НӨАТ буюу бараа, үйлчилгээний татварын системийг ашиглаж байгаа аж. Ердөө арав гаруй жилийн өмнө дэлхийн татварын нийт орлогын 20 орчим хувийг НӨАТ төвлөрүүлж байгаа тухай ЭЗХАХБ-ын Парис хотод болсон 2012 оны НӨАТ-ын талаарх чуулга уулзалтын үеэр яригдаж байв.

8 Flavino Calvino, Chiara Criscuolo and Carlo Menon, Cross-country evidence on start-up dynamics, OECD, PR.,2015, page 6. <https://www.oecd.org/economy/growth/Cross-country-evidence-on-start-up-dynamics.pdf>

9 Liam Ebrill et al, The Modern VAT, International Monetary Fund, Washington, D.C, 2001 page xiv

10 Liam Ebrill et al, The Modern VAT, International Monetary Fund, Washington, D.C, 2001, page 189.

11 Worldwide VAT, GST and Sales Tax Guide 2023 | EY - Global

Аливаа төрлийн татварын асуудлыг судлах тохиолдолд уг татварыг хэний, юунд, хэрхэн, яаж ногдуулдаг талаар авч үзэх шаардлагатай байдаг. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад зааснаар хуулиар ногдуулсан албан татвар төлөх нь иргэний үндсэн үүрэг юм. Манай улс 1998 оны 7 дугаар сараас НӨАТ-ыг нэвтрүүлж эхэлснээс хойших 25 жилийн хугацаанд 2007, 2015 онд НӨАТ-ын тухай хуулийг шинэчлэн баталж, агуулгын хувьд 3 удаа шинэчилжээ. НӨАТ-ын эхний шинэчлэлээр татварын хувь хэмжээг 15-аас 10 болгон бууруулж, дараагийн шатны шинэчлэлээр татварын бүртгэлийн системийг боловсронгуй болгож, цахимд шилжүүлж, төлбөрийн баримтын цахим системийг нэвтрүүлснээр хуурамч падааны зөрчлийг арилгаж, иргэдийн худалдан авалтад төлсөн НӨАТ-ын 2 хувийг иргэдэд буцаан олгох замаар НӨАТ-ын бүртгэлийн системийг сайжруулж, энэ хэрээр далд эдийн засгийг бууруулж, бизнесийг бүртгэлжүүлж, татварын ногдлыг нэмэгдүүлсэн билээ. Улмаар НӨАТ төлөгчөөр бүртгүүлэх борлуулалтын орлогын босгыг жижиг үйлдвэрлэлийн борлуулалтын орлогын босгын жишигт хүргэн өөрчилснөөр жижиг аж ахуйн нэгжүүдийг НӨАТ-ын ачааллаас чөлөөлсөн зэрэг нь цаг үе бүрдээ шийдвэрлэх ач холбогдолтой байв.

Мөн сүүлийн арван жилд НӨАТ-ын удирдлагын зардлыг тооцох, ААН-үүдийн орлого, зардлын тайлагналд НӨАТ-ын шинэчлэлийн үзүүлсэн нөлөө, НӨАТ-ын шинэчлэлд суурилан татварын орлогын бүтцийг оновчтой болгох зарим асуудал, НӨАТ-ын системийг боловсронгуй болгох арга зам, НӨАТ төлөлт, хяналтад дашбоард арга хэрэгсэл ашиглах боломж, НӨАТ-ын бүртгэл, тайлагналыг сайжруулах, НӨАТ-ын хяналтыг банкны төлбөрийн системээр дэмжих боломж зэргийг А.Золзаяа, Б.Лхам-Эрдэнэ, Б.Лхагважав, З.Энхболд, Б.Өнөрмөнх, П.Пунцаг, Б.Болор нар судалсан байна. Түүнчлэн Б.Лхагважав, Р.Энхбат, Ч.Анхбаяр нар 2020 онд “Татварын онол, оновчлол загварчлал” номыг эрхлэн гаргажээ. Эдгээр бүтээлээс харахад НӨАТ-ыг төсвийн орлогын нэг хэсэг болох тухайд, түүнийг хэрхэн хураах, НӨАТ-ын бүртгэл, хяналтын систем талаас буюу захиргаа, удирдлага талаас илүүтэй судалжээ. Харин уг татварыг төлдөг татвар төлөгчийн эрх ашиг талаас, буюу татвар төлөгчид бий болох ачаалал талаас, энэ нь татвар төлөгчийн үйл ажиллагаа, бизнесийн цар хүрээ, хэмжээнээс хамаарч хэрхэн ногдож, ачаалал үүсгэдэг, тэр дундаа ЖДҮ эрхлэгч, гарааны бизнес эрхлэгч нарын хувьд уг татварыг хэрхэн ногдуулах нь үр дүнтэй талаар судалсан судалгааны нээлттэй эх сурвалж хомс байв.

НӨАТ нь шууд бус татвар болохын хувьд үнийн бодлогод нөлөөтэй. НӨАТ-ын хувь хэмжээний өөрчлөлт нь тухайн бараа, ажил, үйлчилгээний эрэлт нийлүүлэлтийн түвшин, цаашлаад инфляцад нөлөөлдөг. Иймээс НӨАТ-ыг зохицуулж буй дотоодын хууль, эрх зүйн орчин хэр зохистой хэрэгжиж байгааг судлах шаардлагатай байлаа. Хөгжиж буй эдийн засагтай улс орнуудын төсвийн орлогын голлох хувийг НӨАТ тэр дундаа импортын НӨАТ-ын орлого эзлэх нь түгээмэл. Манай улсын 2021 оны нэгдсэн төсөвт НӨАТ 25.1 хувь, импортын НӨАТ 13.3 хувьтай байв.

Үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, экспортыг тэлэх бодлого баримталж буй тохиолдолд ЖДҮ эрхлэгч буюу тэр дундаа гарааны бизнест импортын НӨАТ

ачаалал үүсгэж байгаа эсэх нь анхаарал татсан асуудал мөн. Манай улсын хувьд НӨАТ ногдох харилцаа нь гарааны бизнес, том, жижиг бизнес эсэхээс үл хамаарч харилцан ижил нөхцөлөөр ногддог бөгөөд энэхүү НӨАТ хэрхэн ногддог талаарх дэлгэрэнгүй хэсгийг судалгааны НӨАТ хэсэгт дэлгэрэнгүй харуулсан болно. Жижиг бизнесийн хувьд НӨАТ төлөгчийн босгоор дамжуулан НӨАТ суутган төлөгч болох эсэхээс хамаарч НӨАТ-ын харилцаанд оролцох эсэх нь тодорхойлогддог бөгөөд НӨАТ-ын босгын талаар тусгайлан дараах бүлэгт тодорхой харуулна.

Судалгааны зорилго ба судлах асуудал

Энэхүү судалгаагаар ЖДҮ-ийн салбар дахь гарааны бизнест ногдуулж буй импортын НӨАТ-ын өнөөгийн байдал, боловсронгуй болгох боломж, хэрэгцээг тодорхойлох зорилгоор дараах судлах асуудлыг дэвшүүлсэн. Үүнд:

- ЖДҮ-ийн салбар дахь үйлдвэрлэл эрхлэгч нарт үүсэх импортын НӨАТ-ын ачааллын талаар судлахын тулд дотоодын борлуулалтын НӨАТ ногдол, түүнийг хасалт хийхтэй холбоотой харилцаа шууд холбогддог. Энэ агуулгаар НӨАТ төлөгчөөр бүртгэгдэх босго, түүний шаардлага нь ЖДҮ эрхлэгчийн үйл ажиллагаатай хэрхэн уялдах тухай санал боловсруулах;
- ЖДҮ дэх, тэр дундаа гарааны бизнесийн хувьд НӨАТ ба импортын НӨАТ-ын ачаалал ямар байгааг илрүүлэх;
- ЖДҮ эрхлэгчид, тэр дундаа гарааны бизнес эрхлэгчдэд тулгамдаж буй асуудал ба шаардлагатай дэмжлэгийн талаарх асуудлууд багтана.

Судалгааны сэдэв нарийвчлагдсан хэдий ч олон салбар судлагдахууны уулзвар дээр тодорхойлогдох ээдрээтэй асуудал байв. Салбарт тулгамдаж буй асуудлыг нэг удаагийн судалгаагаар тодорхойлох боломж хязгаарлагдмал байдаг ч энэхүү судалгаа нь ЖДҮ эрхлэгчдэд тулгарч буй асуудлыг илрүүлж, гарц шийдлийг олоход тус дэм болох нь дамжиггүй.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

НӨАТ-ын өнөөгийн байдлын судалгаанд ҮСХ-ны өгөгдлийн сан дахь статистик тоон мэдээллийг ашиглахын зэрэгцээ баримтын судалгааны аргыг хэрэглэв. ОУВС-гаас 2001 онд эрхлэн гаргасан “Modern VAT” бүтээлд НӨАТ-ын талаар өгсөн зөвлөмжийг үндэслэл болгож, Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль, тогтоомжид эрх зүйн байх ёстой хэм хэмжээ буюу позитив онолын эмперик болон логик арга зүйгээр дүн шинжилгээ хийлээ.

Мөн чанарын судалгааны аргаар буюу хоёр фокус бүлгийн ярилцлага явуулж, мэдээллийг нэгтгэн боловсруулж, дүгнэлт, санал өгөв.

Судалгааны багийн зүгээс ЖДҮ-ийн салбарт үйлдвэрлэл эрхэлж буй гарааны бизнес эрхлэгчийг илүүтэйгээр сонирхон судалсан хэдий ч жижиг, дунд үйлдвэрлэлийнхэн голдуу худалдаа, үйлчилгээгээ давхар эрхэлдэг онцлогийг харгалзан фокус бүлгийн ярилцлагад үйлчилгээ ба худалдааны гэсэн тодотголтой цөөн төлөөлөл оролцуулсан юм.

Фокус бүлгийн ярилцлагын оролцогчдыг сонгохдоо нийслэлийн “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв” НӨҮГ, “Хөгжлийн шийдэл” ТББ-ын цахим дотоод болон нийгмийн сүлжээнд холбогдох асуулгыг гүүгл форм ашиглан байршуулж, асуулгад хамрагдсан бизнес эрхлэгчдээс дараах дөрвөн үзүүлэлтийн ядаж гурвыг хангасан байх шалгуурыг баримталсан. Үүнд:

- Импортын НӨАТ төлдөг эсвэл импортоор бараа, түүхий эд, материал, тоног төхөөрөмж оруулж ирдэг;
- ЖДҮ-ийн салбарт үйлдвэрлэл эрхэлдэг;
- Үйлдвэрлэлийн салбартай импортын бэлэн бүтээгдэхүүний худалдаа шууд өрсөлдөх шинжтэй байдаг тул фокус бүлгийн ярилцлагад үйлчилгээ эсвэл худалдааны салбарт бизнес эрхлэгчдээс нэгээс хоёр төлөөллийг оролцуулах;
- Гарааны бизнес эрхлэгч буюу одоо эрхэлж буй бизнесийн үйл ажиллагааг 10 хүртэл жил явуулж байгаа хувь хүн, хуулийн этгээд байх.

Ярилцлагад бизнесийн салбарын удирдах эсвэл санхүүгийн албаны шийдвэр гаргах түвшний албан тушаалтан, хувь хүнийг оролцуулж тус бүр найман оролцогчтой хоёр фокус бүлгийн ярилцлагыг зохион байгуулав. Ярилцлагад оролцогч 16 бизнесийг Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 3.2, 4.1.1 дэх заалт болон олон улсын жишгийг үндэслэн бичил (8), жижиг (4), дунд (4) бизнес гэж ангилж боловсруулалт хийсэн.

Фокус бүлгийн ярилцлагыг зохион байгуулахдаа тулгамдаж буй асуудлын хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлж, оролцогчдоор ач холбогдлыг нь эрэмбэлүүлэх аргыг хэрэглэсэн. Ярилцлагад хамгийн олон дурдагдсан санал, сэтгэгдлийн жишээг тайланд шигтгээ болгон оруулсан бөгөөд ярилцлагын гогцоо мэдээллийг холбогдох хууль, эрх зүйн болон судалгааны эх сурвалжаар нягталж баталгаажууллаа.

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР ДАХЬ ГАРААНЫ БИЗНЕСТ НОГДУУЛЖ БҮЙ ИМПОРТЫН НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсөв 18.6 их наяд төгрөг байсан ба үүний 83.7 хувийг татварын орлого, үүний 25.2 хувийг НӨАТ дангаараа бүрдүүлжээ (График 1).¹²

НӨАТ-ын орлого дотоодын бараа, үйлчилгээний НӨАТ, импортын барааны НӨАТ болон НӨАТ-ын буцаан олголт гэх бүтэцтэй. Уг бүтцээс харахад 2022 онд НӨАТ-ын орлогын 69.5 хувийг импортын НӨАТ дангаараа бүрдүүлсэн байна. Өөрөөр хэлбэл 2022 оны улсын төсвийн 14.6 хувь буюу 2.7 их наяд төгрөгийг зөвхөн импортын НӨАТ бүрдүүлжээ.

График 1. Нэгдсэн төсөв дэх татварын орлого ба НӨАТ-ын орлогын бүтэц (их наяд төгрөгөөр)




Улсын төсвийн орлогын бүтцэд эзлэх импортын НӨАТ-ын хувь, хэмжээ өндөр байгаа нь манай улс импортоос өндөр хамааралтай болохыг давхар илтгэж байна (График 2).

12 Үндэсний статистикийн хороо, 2022, МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО, нэр төрлийн ангиллаар, жилээр (www.1212.mn)

График 2. НӨАТ-ын бүтэц, 2021, 2022 он

(дүнд эзлэх хувиар)



Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн босго

ЖДҮ эрхлэгч нар нь НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлснээр НӨАТ-ын хууль, тогтоомжийн дагуу татвар төлж, тайлагнах үүрэгтэй болдог. Энэ агуулгаар уг этгээдүүд нь НӨАТ-ын хууль, тогтоомжоор хариуцлага хүлээх эрх бүхий этгээд болох эсэх асуудал нь НӨАТ суутган төлөгчөөр бүртгэгдэх босгын хэмжээтэй шууд хамааралтай байдаг. Босгыг хэт өндөр тогтоох нь татвар төлөгчдийн тоо, татварын бааз, суурийг бууруулж, татвараас гадуур борлогдох бараа, ажил үйлчилгээний хэмжээ ихсэх боловч нөгөө талаас аж ахуйн нэгжүүдэд учрах татварын дарамтыг багасгах нөлөөтэй. НӨАТ-ын босгыг оновчгүй тогтоосноор НӨАТ-ын тогтолцоо нь гажуудаж, татвар төлөгчдийн дунд тэгш бус байдал үүсгэх ба татварын албанаас өндөр зардлаар илүү хатуу хяналт тавихыг шаарддаг. Учир нь НӨАТ бол бизнесийг бүртгэх нэг хэрэгсэл болдог. Энэ агуулгаар төрөөс НӨАТ-ын тайланг хүлээн авах, НӨАТ суутган төлөгчийг бүртгэхтэй холбоотойгоор татварын албаны зардал ч мөн өсдөг. Нөгөө талаас энэхүү бүртгэлд бүх татвар төлөгчийг хамруулах нь үйл ажиллагааны орлого багатай жижиг бизнес эрхлэгчийн хувьд илүү захиргааны зардал үүсгэдэг талаар олон судлаач санал нэг байдаг. Иймээс ч НӨАТ-ын харилцаанд орох этгээдийг сонгохдоо бизнесийн үйл ажиллагаанд тогтмол оролцдог, жижиг бизнес эрхлэгчээс дээш борлуулалтын орлоготой бизнесийг хамруулах хандлага олон улсад түгээмэл байна.

ОУВС-гийн судалгаанаас үзэхэд НӨАТ-тай орнуудын татвар төлөгчдийн хамгийн өндөр борлуулалтын орлоготой 10 хувь нь нийт НӨАТ-ын орлогын 90 хувийг бүрдүүлдэг тухай тооцоо гарсан байна. Үүнээс үзэхэд НӨАТ-т бүх нийтийг хамруулах оролдлого нь хэт бага орлоготой хэсгээс багахан хэмжээний татварын орлого хураахын тулд өндөр зардал гаргаж байж болзошгүй юм. Шинэ Зеланд Улсад хийсэн судалгаанаас үзэхэд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн НӨАТ төлөх зардал нь нийт эргэлтийнх нь 21 орчим хувийг эзэлдэг байна.

НӨАТ төлөгчөөр бүртгэгдэх босгыг борлуулалтын орлогын хэмжээгээр тогтоох нь нийтлэг боловч зарим улс орон үйл ажиллагааны чиглэл, салбараар нь ялгаатайгаар тогтоодог. Жишээ нь, Буркина Фасо, Ирланд, Индонез зэрэг улсад үйлчилгээний салбарт босгыг арай доогуур тогтоосон байна. Японд 30-50 сая иен, Голландад 2173-4150 гульденy жилийн борлуулалттай татвар төлөгчдийг хөнгөвчилсөн хэлбэрээр татварт хамруулах арга хэмжээ авчээ. Харин Итали, Испани, Хятад, Филиппин зэрэг орнуудад босгоос доогуур орлоготой татвар төлөгчдөд бага (2-4 хувь) хувь хэмжээгээр гүйлгээний татвар ногдуулдаг байна.

ОУВС-гаас 2001 онд манай улсын НӨАТ-ын босгыг 18,750 доллар байхыг санал болгож байсан ба өнөөдрийн ханшаар тооцож үзвэл 65 сая орчим төгрөгтэй дүйцэж байна¹³.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль¹⁴-ийн 3.1, 5.2 дахь хэсгийг үндэслэн хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны жилийн борлуулалтын орлогын хэмжээ 50 сая ба түүнээс дээш төгрөгт хүрсэн өдрөөс эхлэн НӨАТ суутган төлөгч болдог ба энэ зохицуулалт нь 2016 оноос эхлэн хэрэгжиж байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль батлагдах үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль¹⁵-ийн дагуу (тус хууль 2019 онд хүчингүй болсон) “дунд үйлдвэрлэл эрхлэгч” гэж “ажиллагчдын тоо нь 199-өөс дээшгүй бөгөөд 1.5 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэнийг, “жижиг үйлдвэрлэл эрхлэгч” гэж ажиллагчдын тоо нь 19-өөс дээшгүй бөгөөд үйлдвэрлэл эрхэлдэг, 50-250 сая төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий жижиг үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж, иргэн” гэж тодорхойлж байсан. Энэ агуулгаар НӨАТ-ын босгыг жижиг үйлдвэрлэл эрхлэгчийн жилийн борлуулалтын орлогын доод хэмжээтэй ижил байдлаар тогтоосон байдаг (Хүснэгт 6).

Хүснэгт 2. НӨАТ суутган төлөгчийн босго ба ЖДҮ, үйлчилгээ эрхлэгч

| | | Хүчин төгөлдөр хууль | | Хүчингүй болсон хууль | |
|----------|------------------------|--|--|---|--|
| Үзүүлэлт | | Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль (2019 он) | Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль (2015 он) | Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль (2007 он) (Үйлдвэрлэл эрхлэгч) | Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль (2006 он) |
| | | | НӨАТ-ын босго | | НӨАТ-ын босго |
| Бичил | Ажилтны тоо | <10 | 50 сая | - | 50 сая |
| | Жилийн нийт борлуулалт | <300.0 сая ₮ | | - | |

13 Liam Ebrill et al., The Modern VAT, International Monetary Fund, Washington, D.C., 2001 page 114

14 Төрийн мэдээлэл 2015 он, №29

15 Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2007 он, №32

| | | | | | |
|-------|------------------------|---------------------------|--------|------------------------|--------|
| Жижиг | Ажилтны тоо | 10<50 | 50 сая | <19 | 50 сая |
| | Жилийн нийт борлуулалт | 300.0 сая ₮ < 1 тэрбум ₮ | | 50.0 сая ₮ < 250 сая ₮ | |
| Дунд | Ажилтны тоо | 50<200 | | <199 | |
| | Жилийн нийт борлуулалт | 1 тэрбум ₮ < 2.5 тэрбум ₮ | | <1.5 тэрбум ₮ | |

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

Тэгвэл одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хуульд “жижиг” бизнес эрхлэгчийн борлуулалтын орлогын хамгийн доод хэмжээ нь 300 сая төгрөг байгаа ба өмнө хэрэгжиж байсан хуулийн жишгийн дагуу НӨАТ төлөгчөөр бүртгүүлэх босгыг тогтоох бол түүний босго 300 сая төгрөгөөс багагүй байх боломжтой.

Энэхүү босгын талаар судалгаанд оролцогчдын зүгээс дүгнэхдээ:

Шигтгээ 1. НӨАТ суутган төлөгчийн босго

Дунд бизнес. 4D шалавч үйлдвэрлэгч, НӨАТ-ын босго 50 сая гэдэг үнэхээр бага. Инфляцтайгаа уялдсан юм байхгүй. Бараг энэ чинь 10 жилийн өмнө тогтоосон босго. Гарааны бизнес дөнгөж эхэлж байгаа үед бөөн мөнгө ч байхгүй, НӨАТ төлөх туршлага ч байхгүй. Тэгээд нэг юм хийх гээд алдаатай, оноотой явж байтал НӨАТ төлөгч болчихдог. Тэгээд тэр 15.5 хувийг төлж чадахгүй.

Ярилцлагын мэдээллээс үзэхэд НӨАТ суутган төлөгчийн босго бичил үйлдвэрлэлд илүү дэмжлэг болдог ба харин жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчийн хувьд хэтэрхий доогуур гэх дүр зурагтай байв.

Одоо хүчин төгөлдөр мөрдөж буй хуулийн 50 сая төгрөгийн босгыг Монгол Улсын Засгийн газар, Сангийн яамнаас 2013 онд хийж байсан судалгаагаар ОУВС болон Торонтогийн их сургуулийн судлаач Michael Keena, Jack Mintz нарын 2002 онд хэвлэгдсэн НӨАТ-ын оновчтой босго тогтоох загвар¹⁶-ыг ашиглан тогтоосон байдаг.

Тус загварын томъёо:

$$z = \frac{\delta A + B}{(\delta - 1)\tau\phi(z)}$$

z - НӨАТ-ын босгын оновчтой хэмжээ

δ - Нийгмийн бүтээмжид (public funds) ногдох ахиуц зардал

A - Татварын албаны татварын орлого төвлөрүүлэхтэй холбоотой зардал

16 Michael Keena, Jack Mintz, The optimal threshold for a value-added tax, Journal of Public Economics 88, 2004, Page 562-563

В - Татвар төлөгчийн татварын хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан зардал

Т - НӨАТ-ын хувь, хэмжээ

φ(z) - Борлуулалтад шингэсэн нэмүү өртгийн хувь, хэмжээг тус тус илэрхийлдэг.

Тус загварын дагуу тооцооллыг 2022 оны тоон мэдээлэлд үндэслэн хийж үзвэл НӨАТ төлөгчийн босго 210 сая төгрөг байж болохоор байна.

Хүснэгт 3. НӨАТ төлөгчийн босго

| Үзүүлэлт | Томьёо | Хэмжээ, нэгж | Тооцоолол/ тайлбар |
|---|--------|----------------|---|
| Татварын албаны зардал | А | 132,000 төгрөг | 1,320,000 ¹⁷ төгрөг (Төрийн захиргааны албан хаагчийн цалингийн шатлалын ТЗ-7 зэрэглэлээр татварын байцаагчийн сарын дундаж цалинг тооцов) * 30 хувь (ажлын цагийн 30 хувийг НӨАТ-д зарцуулдаг) / 3 (Сард дунджаар 3 аж ахуйн нэгжийг хянадаг) |
| Татвар төлөгчийн зардал | В | 681,818 төгрөг | 3,000,000 ¹⁸ төгрөг (нягтлан бодогчийн сарын дундаж цалин) * 22.7 хувь (ажлын цагийн 22.7 хувь буюу 1 сард ажлын 5 өдрийг зарцуулдаг) |
| Борлуулалтад эзлэх нэмүү өртгийн хэмжээ | φ(z) | 14 хувь | (92 их наяд төгрөг (нийт борлуулалт) - 79 их наяд төгрөг (худалдан авалтын нийт дүн)) / 92 тэрбум төгрөг (нийт борлуулалт) ¹⁹ |
| Татварын хувь хэмжээ | Т | 10 хувь | Одоо мөрдөж буй хуулийн хувь, хэмжээ |
| Нийгмийн бүтээмжийн ахиуц зардал | δ | 1.29 | (53.85 их наяд төгрөг (2022 оны ДНБ) + 15.57 их наяд төгрөг (улсын төсвийн татварын орлого ²⁰)) / 53.85 их наяд төгрөг (2022 оны ДНБ) ²¹ |

$$Z = \frac{1.29 * 132,000 + 681,818}{(1.29 - 1) * 0.1 * 0.14} \approx 209,876,354$$

Дээрх тооцоог үндэслэвэл, НӨАТ суутган төлөгчөөр бүртгэгдэж, татварын тайлан

17 Татварын улсын байцаагч нь төрийн захиргааны ТЗ-7 буюу дэс түшмэлийн албан тушаалтай гэж үзэж Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаас

18 www.zangia.mn сайтад зарлагдсан нягтлан бодогчийн зар дээр ерөнхий буюу ахлах нягтлан бодогчийн цалин 2,5 саяас 5 сая байна. Харин туслах нягтлан бодогч, тооцооны, бараа материалын гүйлгээний зэрэг нягтлан бодогчийн хувьд туршлагаас хамаарч 1.5 саяас 2.8 саяын хооронд байна. Иймээс тухайлсан 1 нягтлан бодогчтой байгууллагын хувьд гаргах хамгийн бага зардал нь ерөнхий нягтлан бодогчийн зардал гэж тооцлоо.

19 Татварын ерөнхий газрын тоон мэдээ, 2022 он

20 Үндэсний статистикийн хороо, 2022, МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО, нэр төрлийн ангиллаар, жилээр (www.1212.mn)

21 Үндэсний статистикийн хороо, 2022, ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, үйлдвэрлэлийн аргаар, салбараар

гарган, борлуулалтдаа НӨАТ ногдуулан төлөх одоогийн 50 сая төгрөгийн босго бичил бизнес эрхлэгчид хамаарахгүй байна. Харин хуулиар тодорхойлогдсон жижиг бизнесийн хувьд уг татварын харилцаанд орох нөхцөл үүсэж байна. Иймээс НӨАТ-ын хуулийн шинэчлэлийн хүрээнд тогтоосон босгын суурь дүнг өнөөдрийн хууль тогтоомжийн өөрчлөлт, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулж 210 сая төгрөг байх боломжтой гэж үзэв.

НӨАТ ногдуулалт, хувь хэмжээ

НӨАТ нь манай улсын хувьд дотоодод борлуулах, импортлох, экспортлох бүх төрлийн бараа, ажил, үйлчилгээнд ногддог. НӨАТ ногдуулахгүйн тулд уг татвараас чөлөөлөх зохицуулалтыг хуульчлан баталдаг. Хуулиар чөлөөлөхөөр зааснаас бусад тохиолдолд бүх бараа, ажил, үйлчилгээний борлуулалт, импорт, экспорт нь НӨАТ-тай байна. Манай улсад бараа, ажил, үйлчилгээний борлуулалт, импортод 10 хувиар НӨАТ ногдуулдаг бол экспортод НӨАТ-ыг чөлөөлөх болон 0 хувиар татвар ногдуулдаг. Энэхүү 0 хувийн НӨАТ нь экспортлогч нарт ач холбогдолтой зохицуулалт бөгөөд дотоодод нэмүү өртөг үүсгэн төлсөн НӨАТ-ыг бараа, бүтээгдэхүүнийг экспортлох үед бүхэлд нь буцаан авах боломжийг бий болгодог.

“Ernst & Young”-ийн 2023 оны судалгаагаар нийт 149 улсын НӨАТ-ын талаар судалсан ба үүнээс НӨАТ-ын хувь, хэмжээ нь импортын бараанд нэг шатлалаар ногддог 50 улс байгаа ба үүний нэг нь манай улс юм. Харин бусад улс нь стандарт хувь болон бууруулсан хувь буюу тусгай хувь хэмжээгээр НӨАТ ногдуулдаг байна (Хүснэгт 4).²²

Хүснэгт 4. Зарим улсын НӨАТ-ын хувь, хэмжээ

| Улсын нэр | Стандарт хувь | Бусад хувь | 0 хувь |
|----------------|---------------|-------------------------|--------|
| Албани | 20% | 6 | 0% |
| Ангол | 14% | 7%, 5% | 0% |
| Австри | 20% | 19%, 13%, 10%, 5% | 0% |
| Бельги | 21% | 12%, 6% | 0% |
| Чили | 19% | 15% - 50% | - |
| БНХАУ | 13% | 9%, 6%, 5%, 3% | 0% |
| Колумб | 19% | 5% | 0% |
| Фижи | 15% | 9% | 0% |
| Финланд | 24% | 14%, 10% | 0% |
| Франц | 20% | 10%, 5.5%, 2.1% | 0% |
| Гүрж | 18% | - | 0% |
| Герман | 19% | 7% | 0% |
| Энэтхэг | 28% | 18%, 12%, 5%, 3%, 0.25% | 0% |
| Индонез | 11% | - | 0% |
| Итали | 22% | 10%, 5%, 4% | 0% |
| Япон | 10% | 8% | - |
| Казахстан | 12% | - | 0% |
| Өмнөд Солонгос | 10% | - | 0% |

22 Worldwide VAT, GST and Sales Tax Guide 2023 | EY - Global, https://www.ey.com/en_gl/tax-guides/worldwide-vat-gst-and-sales-tax-guide

| Улсын нэр | Стандарт хувь | Бусад хувь | 0 хувь |
|-------------|---------------|------------|--------|
| Монгол | 10% | - | 0% |
| Нидерланд | 21% | 9% | 0% |
| Шинэ Зеланд | 15% | 9% | 0% |
| Швейцар | 7.7% | 3.7%, 2.5% | 0% |
| Тайланд | 7% | - | 0% |
| Турк | 20% | 10%, 1% | - |
| Их Британи | 20% | 5% | 0% |
| АНУ* | 2.9% - 10.3% | - | - |
| Вьетнам | 10% | 5% | - |

Тайлбар: *-муж улс бүрд НӨАТ-ын хувь хэмжээ харилцан ялгаатай.

НӨАТ суутган төлөгч нь сар тутам НӨАТ-ын тайлан гаргаж, үйлдвэрлэл, үйлчилгээний борлуулалтын НӨАТ-аас худалдан авалтын НӨАТ-ыг хасагдуулах замаар нэмүү өртөгт төлсөн НӨАТ-ыг улсын төсөвт төлдөг. Өөрөөр хэлбэл, худалдан авалтад төлсөн НӨАТ болон борлуулалтын НӨАТ-аа тайлагнадаг.

НӨАТ-ын хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүргийг татварын алба, гаалийн байгууллага тус тус хэрэгжүүлж, хяналт тавьдаг бөгөөд импортын НӨАТ-ын хувьд гаалийн байгууллага, дотоодын НӨАТ-ын борлуулалт, тайлагналд татварын байгууллага тус тус хяналт тавьж ажилладаг.

НӨАТ суутган төлөгч байх нь тухайн бизнес эрхлэгчид бизнесийн харилцаанд оролцоход чухал хөшүүрэг боловч ЖДҮ-ийн хувьд НӨАТ суутган төлөгч байх шалгуурыг хангаж ажиллахын тулд багагүй бэрхшээлтэй тулгардаг байна.

Судалгаанд оролцогчдын өгсөн мэдээллээс дүгнэхэд бичил аж ахуй эрхлэгчдийг татвар гэхээсээ бараагаа хаана, хэрхэн борлуулах асуудал илүүтэй зовоодог бол жижиг, дунд бизнес эрхлэгчдэд татвар дарамттай байдаг ажээ. Үүний учир нь НӨАТ-ын хувь, хэмжээнд биш, түүнийг бүрдүүлэх процесс ойлгомжгүй, хүндрэлтэй, үйлдвэрлэлийг биш импортын бэлэн барааг оруулахыг дэмждэгээрээ хорон байдагт оршдог байна.

Шигтгээ 2. (а, б, в). НӨАТ ногдуулалт, хувь хэмжээний тухайд

2а) Дунд бизнес. 4D шалавч үйлдвэрлэгч: Ер нь НӨАТ дэлхийн улс орнуудын хэмжээнд 10 хувь түүнээс дээш байдаг юм билээ. Одоо ЖДҮ дээр НӨАТ дарамт болоод байгаа юм алга. Импортын бэлэн бүтээгдэхүүн чинь л биднийг өсөж өндийхгүйгээр дарж байна. Ерөөсөө л тэр.

2б) Дунд бизнес. Хүнсний үйлдвэрлэгч: Ер нь энэ дотроос татвар багасга гэдэг санал нэг ширхэг ч байхгүй. Маш энгийн юм ярьж байна. Тэгш болгоод өгөөч. Би энд юм үйлдвэрлэх гээд зовж байхад тэнд нэг нөхөр зүгээр контейнерт ижил бараа оруулж ирчихээд дор хаяж 15 хувийн бага үнээр зарах боломжийг үүсгэж байна.

Зарим жижиг, дунд бизнес эрхлэгч нар одоо мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн системд сэтгэл дундуур байв. Мөн бараа борлогдохоос өмнө и-баримт шивдэг, татварын ба нийгмийн даатгалын байцаагчид данс хаадаг зэрэг нь ЖДҮ эрхлэгч нарт багагүй хүндрэл учруулдаг ажээ.

2в) Дунд бизнес. Нягтлан бодогч: *Татвар өндөр байгаа нь асуудал ерөөсөө биш. Түүнийг авч байгаа алхам, шатлал, заавал тийм байх ёстой гэдэг процесс нь маш хүнд байна.*

Бараа, ажил, үйлчилгээг борлуулсан болон үзүүлсэн тохиолдолд шууд НӨАТ-ыг тооцдог нь буруу. Манайх аккрузал сууриар тооцдог нь хөрсөн дээр буудаггүй юм шиг санагддаг.

Номинд би 10 ширхэг варень нийлүүллээ. "Номин" барааг аваад и-баримтаар шивээд өгчихдөг болчихсон, нэхэмжлэл үүслээ бол зарлагын баримт и-баримт шивэгддэг болчихсон. Процесс нь ийм байгаа, дахиад асуудал. Нөгөө л мөнгөн суурь, аккрузал суурь гэдэг юмаа эргээд харах ёстой. Тэгээд өр үүсгээд байна. Өрийг бид төлнө шүү дээ. Төлөхгүй гээгүй байна. "Төлөөч ээ" гээд дарамтлаад байдаг процесс нь хэцүү. Орлого олоогүй байж шууд өрөнд орж байгаа. Төл гэж дарамталдаг. Данс хаадаг. Данс нээлттэй бол ядаж 10 саяын орлого ороод ирвэл 5 саяар бараагаа захиалаад, 3 саяыг цалиндаа тавиад, 2 саяыг татварын өрөнд өгмөөр байдаг. Энэ процессыг хаагаад хаячихдаг.

Миний бодлоор гаалийн татвар, НӨАТ-ыг ЖДҮ эрхлэгч бэлнээр өгөөд байна шүү дээ. НӨАТ дээр бол тэртэй тэргүй бид дараа төлөлтөөр өглөг, авлагаар мөнгөө тооцдог юм чинь импортын НӨАТ-ыг борлуулсны дараа, тухайн сарын тайлан гарсны дараа өгдөг байж болохгүй гэж үү?

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль²³-ийн 3.1.1, 6.1-д заасны дагуу Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтлөх буюу мөнгө хүлээн авсан, эсхүл төлсөн эсэхээс үл хамааран орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэдэг. НӨАТ-ын тухай хуулийн 10.2-т "Бараа, ажил, үйлчилгээ борлуулсан тухай бүрд борлуулалтын орлогыг хүлээн авсан өдөр, төлбөрийн баримт, нэхэмжлэл үйлдсэн өдөр эсхүл бараа, үйлчилгээг худалдан авсан өдрийн аль түрүүнд хийгдсэн өдрөөр албан татвар ногдуулах хугацааг тогтооно", 10.5-д "Бараа импортоор оруулсан бол уг барааг гаалийн байгууллагад мэдүүлсэн өдрөөр албан татвар ногдуулах хугацааг тогтооно" гэж зааснаар НӨАТ нь мөнгөн болон аккрузал хосолсон сууриар ногдож байгаа нь ЖДҮ эрхлэгч нарт хүндрэл үүсгэдэг нь судалгааны явцад харагдлаа.

Манай улсын НӨАТ-ын хувьд нутаг дэвсгэрийн зарчим үйлчилдэг. Энэ зарчим ёсоор хэрэглээ хаана бий болж байна тэнд НӨАТ ногдох ёстой. Өөрөөр хэлбэл үйлдвэрлэгч буюу экспортлогч нь үйлдвэрлэлийн үе шатанд төлсөн НӨАТ-ыг хуримтлуулаад борлуулах явцад буюу хэрэглэгчид очих явцад НӨАТ нь ногдож, үйлдвэрлэгч өөрийн нэмэгдэл өртөг дээрээ л уг татварыг төлдөг. Харин татварын бусад ачаалал нь эцсийн хэрэглэгчид шилжих ёстой ч татварын суурь хосолмол

23 Төрийн мэдээлэл эмхэтгэл., 2015, №27

байгаагаас хамаарч, мөнгөн төлбөр бүрэн төлөгдөх хүртэлх хугацаанд ЖДҮ эрхлэгч уг татварын ачааллыг үүрч байна. Харин эцсийн бүтээгдэхүүнээ дотоодод бус гадагш гаргах ЖДҮ эрхлэгч нарын хувьд эцсийн бүтээгдэхүүний экспортын НӨАТ "0" хувьтай байдгаас нэмэгдэл өртөг бий болгоход төлсөн татвараа буцаан авах боломжтой болдог байна.

Шигтгээ 3. Бичил экспорт

Бичил бизнес. Зөөлөн оёдол болон дээл үйлдвэрлэгч: Миний хувьд урагшаа хэдэн дээлээ борлуулах гээд аваад явахад манай улсаас ямар ч татвар авдаггүй. Амжилт хүсье гээд гаргаад явуулдаг. Хятадын хил дээр очоод татвар төлдөг. Хятадад би 5 хувийн татварыг тухайн барааны тоо ширхгээс хамааруулаад төлдөг. Үнийг Хятадын тал тогтоодог. Нэг ширхэг дээлийн дундаж үнийг 600 юань гэж тогтоогоод тэр үнээс 5 хувийн татвар авдаг. Тэгэхээр ямартай ч экспортод гарч байгаа бүтээгдэхүүнийг Монгол Улс дэмжиж байгаа.

Шигтгээ 4. ЖДҮ эрхлэгчийн эргэцүүлэл

Жижиг бизнес. Зөөлөн оёдол - маск үйлдвэрлэгч: Яг үнэндээ Монгол Улс гаднаас татваргүй орж ирж байгаа барааг дэмжээд байна. Манайх өөрсдөө хязгаар тавьдаг байвал гоё байна. Тэдэн тооны тийм бараа байна, ийм үнээр үнэлж байна. Мөнгөө, татвараа төл гээд. Тэгвэл аливаа юм чанартай болно.

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгч нараас НӨАТ-ын экспортын бодлого, хувь, хэмжээнд сэтгэл хангалуун байгаа ч НӨАТ ногдуулалт буюу татвар ногдох хугацааны хувьд дарамттай байгаа талаар дурдсан нь манай хуулийн НӨАТ ногдох хугацаатай холбоотой байна. Түүнчлэн импортын НӨАТ нь үйлдвэрлэл биш, бэлэн бүтээгдэхүүний худалдааг дэмжээд байна гэж үзсэн байна.

Импортын нэмэгдсэн өртгийн албан татвар ба бүртгэл

Импортын НӨАТ нь үйлдвэрлэлийн гинжин хэлхээнд татварыг үр дүнтэй хураах чухал хэсэг болж чаддагаас гадна урт хугацаанд НӨАТ-ын бүртгэлийг амжилттай хийх боломж олгодог.²⁴ Нөгөө талаар Засгийн газраас үндэсний үйлдвэрлэлийг дэмжих зорилготойгоор худалдааны бодлогын тарифын бус аргаар хил дээр импортын барааны НӨАТ-ыг урьдчилсан байдлаар хэрэгжүүлдэг²⁵ гэж судалгааны бүтээлүүдэд дурдсан байна. Дээрх судалгааны дагуу импортын НӨАТ нь худалдааны бодлогод нөлөөлдөг хэрэгсэл байхаас гадна, үйлдвэрлэлийн гинжин хэлхээнд НӨАТ ногдох анхдагч бүртгэлийн цэг гэж авч үзсэн байна. Гэвч, манай улсын хувьд импортын барааны хилийн хяналт хангалттай сайн биш бөгөөд үүнээс болж татварын бодлого тэгш бус үйлчилж байгаа талаар судалгаанд оролцогчид байнга дурдсан. Өөрөөр хэлбэл, хилээр оруулж байгаа бараагаа бүрэн бүртгэж

24 Liam Ebrill et al., The Modern VAT, International Monetary Fund, Washington, D.C., 2001, page 49.

25 А.Даваасүрэн нар., Гадаад худалдаан дахь тарифын болон тарифын бус зохицуулалт, Монгол Улсын Шинжлэх ухааны академи, олон улс судлалын хүрээлэн, Улаанбаатар., 2022, 21 дэх тал.

чадахгүй байгаагаас дотоодын борлуулалтыг бүртгэх боломжгүй болж, энэ нь далд эдийн засгийг үүсгэх хүчин зүйл болж байна.

Гаалийн тухай хууль²⁶-ийн 8.1-т “Хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурал улсын хилээр оруулах, гаргахыг хориглох барааны, Засгийн газар тарифын бус хязгаарлалттай нэвтрүүлэх барааны жагсаалтыг тухайн барааны ангиллын кодыг Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем (БТКУС)-ийн дагуу зааж тус тус батална” гэж заасны дагуу импортын барааны бүртгэл нь БТКУС-ийн дагуу тодорхойлогддог байна. БТКУС-ийн ангилал нь гаалийн хилээр оруулах бараанд татвар ногдуулах зорилгоор тодорхойлсон код байдаг бөгөөд энэ нь дотоодын барааны борлуулалтад ашиглагддаггүй нь НӨАТ-ын бүртгэлийг зохих ёсоор хэрэгжүүлэхэд хүндрэл учруулдаг байна. Өөрөөр хэлбэл, дотоодын борлуулалт буюу татварын бүртгэлийн цахим системд уг барааны бүртгэл нь БТКУС ангиллаар бүртгэгддэггүй болно. Иймээс ч дээрх судалгаанд дурдсанчлан импортын барааны НӨАТ нь НӨАТ-ын бүртгэлийг хийх сайн суурь болж чадахгүй байх тул дээрх импортын бараа болон түүнийг дотоодод дахин борлуулах үед ижил ангилал, кодоор бүртгэн, НӨАТ-ын гинжин хэлхээг таслахгүй байх нөхцөлийг бий болгох нь зүйтэй байна.

Энэ хүрээнд төр, захиргааны байгууллагуудаас гаргасан тодорхой баримт бичгүүдээс судлан үзэхэд, Чөлөөт бүсийн тухай хууль, Хүнсний аюулгүй байдлын тухай хууль, “Бизнесийн таатай орчин бүрдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 143 дугаар тогтоолоор Монгол Улс Олон улсын бараа, бүтээгдэхүүнийг кодлох Европын байгууллагад элссэнтэй холбогдуулан бараа, бүтээгдэхүүний “Зураасан код” хэрэглэх үйл ажиллагааг дэмжиж ажиллахыг холбогдох сайд нарт даалгасан байна. Иймээс ч импортын бараанд БТКУС-ээс гадна, зураасан кодыг ашиглаж, үүнийг дотоодын борлуулалтад нэвтрүүлэх нь НӨАТ-ын бүртгэлийг хийх хамгийн боломжит хувилбар гэж дүгнэж байна.

Импортын нэмэгдсэн өртгийн албан татварын ногдол ба жижиг, дунд үйлдвэрлэл

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 16.2.1-д заасны дагуу гаалийн байгууллага нь импортын барааны НӨАТ-ыг ногдуулан авч, төсөвт шилжүүлдэг. Импортын барааны НӨАТ тооцох үнэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 9.1.1-д заасны дагуу гаалийн үнэ дээр гаалийн албан татвар, онцгой болон бусад албан татварыг нэмж тооцсон дүнгээр тооцож гаргадаг бөгөөд уг үнээс 10 хувиар тооцож НӨАТ ногдуулдаг.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулиар болон бие даасан хуулиар НӨАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлдэг. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу нийтдээ 49 төрлийн бараа, үйлчилгээ нь НӨАТ-аас чөлөөлөгддөг ба үүнээс жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчийн дотоодын зах зээлийг дэмжих зорилгоор хэрэгжүүлэх НӨАТ-ын чөлөөлөлт нь 8 байна. Харин жижиг, дунд үйлдвэрлэл

²⁶ Төрийн мэдээлэл эмхэтгэл., 2008, №23

эрхлэгчийн үйл ажиллагаатай холбоотой импортын НӨАТ-аас чөлөөлөх хуулийн 13.1.19 зохицуулалт нь инновацийн төслөөр дотоод, гадаадын зах зээлд шинэ бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулахад шаардлагатай, дотоодод үйлдвэрлэдэггүй түүхий эд, материал, урвалж бодист л хамаарч байна.

Хуулийн нэгдсэн сан www.legalinfo.mn цахим сайтаас харахад, НӨАТ-аас чөлөөлөх бие даасан 31 хууль байна. Үүнээс жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчийн импортын дэмжлэг, чөлөөлөлттэй холбоотой нь 5 байна. Үүнээс дараах 2 төрлийн чөлөөлөлт хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Үүнд:

- Импортоор оруулж байгаа болон дотоодод борлуулсан хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, усалгаа, хүлэмжийн тоног төхөөрөмж, ойн болон шувууны аж ахуйн техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл;
- Дархан-Уул аймагт барих арьс, шир, ноос, ноолуур боловсруулах цогцолборын дэд бүтцийн, үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах тоног төхөөрөмжийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл.

Дээрх хуулийн зохицуулалтаас харахад, ЖДҮ эрхлэгчийн хувьд импортын НӨАТ-тай холбоотой шууд дэмжлэг бараг байхгүй гэж хэлж болно. Үүний дээр НӨАТ-аас чөлөөлөгддөг бараа, үйлчилгээний тухай болон импорттой холбоотой мэдээллийг ЖДҮ эрхлэгчдэд ойлгомжтой хэлбэрээр шуурхай хүргэх явдал шаардлагатай байна.

“Ernst & Young”-ийн 2023 оны судалгаанд дурдагдсан дэлхийн улс орнуудын жижиг, дунд бизнес үйлчилдэг НӨАТ-ын тогтолцооны нийтлэг зохицуулалтыг авч үзвэл:

- ЖДҮ эрхлэгч нарыг НӨАТ төлөгчийн бүртгэлээс чөлөөлөх, үүнтэй холбоотой НӨАТ тайлагнах, төлөх зэрэг үүргээс давхар чөлөөлж байна;
- ЖДҮ эрхлэгч нарын хувьд НӨАТ-ын хялбаршуулсан тайланг гаргах буюу улирлаар тайлан гаргахыг зөвшөөрөх, бууруулсан хувь, хэмжээгээр татвар ногдуулах;
- НӨАТ-ын бүртгэлийг мөнгөн сууриар гүйцэтгэхийг зөвшөөрөх;
- ЖДҮ-ийн тоног төхөөрөмжийг импортын татвараас чөлөөлөх;
- Гаалийн татварыг тодорхой хугацаагаар хойшлуулах боломжтой байх;
- ЖДҮ эрхлэгчийн хувийн зорилгоор импортлох барааны НӨАТ-ыг буцаан олгох.

Дээрхээс дүгнэвэл, ЖДҮ эрхлэгч нарын хувьд НӨАТ-ын хувь, хэмжээний тал дээр хүндрэл үүсдэггүй хэдий ч НӨАТ-ын ногдол, тайлагналтай холбоотой бүртгэлийн суурийг мөнгөн суурь болгон өөрчлөх, тайланг хялбаршуулах, НӨАТ суутган төлөгчийн босгыг жижиг бизнес эрхлэгчийн хэмжээнд буюу 210-300 сая төгрөгийн хооронд болгон тооцох нь зүйтэй байна.

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛД НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ДАРАМТ ҮҮСГЭЖ БҮЙ АСУУДЛУУД

НӨАТ нь шууд бус татвар болохын хувьд үнийн бодлогод нөлөөтэй. НӨАТ-д төлсөн үнийн дүн тухайн бараа, ажил, үйлчилгээний эрэлт нийлүүлэлтийн түвшин, цаашлаад инфляцад нөлөөлдөг. Иймд импортын бараанд төлсөн НӨАТ тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний өртөгт шингэсэн байх ёстой юм.

Бичил, жижиг, дунд ба том хэмжээний үйлдвэрлэл нь бүхэлдээ Монгол Улсын эдийн засгийг бүрдүүлдэг бөгөөд эдгээрийн аль нэгийг нь үйл ажиллагаа доголдох бол эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж, Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээнд ч нөлөөлдөг байна. Энэ агуулгаар үйлдвэрлэлийн аль нэг хэсэгт доголдол үүсгэх нь үйлдвэрлэл нарийнтах нөхцөлийг үүсгэх юм. Өөрөөр хэлбэл жижиг, дунд гэлтгүй бизнесийн үйл ажиллагаа доголдох нь Монгол Улсын эдийн засгийн бүтцэд гажиг үүсгэж, зах зээлийн зарчмаар эдийн засаг тэлэх нөхцөл боломжийг бууруулах сөрөг нөлөөтэй. Гарааны бизнес эрхлэгч, жижиг, дунд үйлдвэрлэлд импортын НӨАТ хэрхэн нөлөөлж байгааг судлах явцад импортын НӨАТ нь агуулгаараа бүрэн хэрэгждэггүй дүр зураг харагдав. Энэ нь эргээд төрийн бодлого уг салбарт төдийлөн оновчтой биш байгааг илтгэж байна. Эл судалгаа шинжилгээний үр дүнд илэрсэн асуудлуудыг НӨАТ төлөлтийн ба хэрэгжүүлэлтийн дутмагшил хэмээн судлаачийн зүгээс тодорхойлж ангилж байна.

Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөлтийн дутмагшил

Барааг хилээр нэвтрүүлэх үед импортын НӨАТ-ыг төлөх шаардлага тавьдаг. Харин дотоодын НӨАТ нь бараа, ажил, үйлчилгээний худалдан авалт болон импортод төлсөн өмнөх шатны НӨАТ-ыг борлуулалтын НӨАТ-аас хасаж тооцон, тайланд тусган ногдуулсны дараа төлдгөөрөө ялгаатай. Иймээс ч импортын барааны НӨАТ нь бизнес эрхлэгчийн хувьд шууд ачаалал болдог тул түүнээс зайлсхийх арга зам хайдаг нь тэдэнд эргээд илүү дарамт болж буух нь цөөнгүй байна.

5а). Жижиг бизнес. Зөөлөн оёдол-маск үйлдвэрлэгч: Түүхийг эдээ импортоор, каргогоор НӨАТ төлөхгүйгээр оруулаад ирдэг. Эргээд бүтээгдэхүүнээ зарахад НӨАТ-ын дарамтад орж байгаа. Яагаад гэхээр түүхий эд маань НӨАТ-гүй орж ирээд байгаа. Одоо НӨАТ-ын 30-40 сая төгрөгийн өртэй. Хэрвээ НӨАТ-тай орж ирдэг бол уг нь өргүй баймаар ч юм шиг. Тэгсэн мөртөө зарж байгаа юм нь НӨАТ-тай. Үүнээс гадна борлуулалтаа бодоод ЖДҮ чинь бараагаа НӨАТ-гүй зарчихдаг. Тэгэнгүүт цаад газраас²⁷ НӨАТ өгөөгүй гээд асуудалд мануусыгаа унагачихдаг. Е-баримтаа өгөөгүй л дээ. Яагаад гэхээр хэрэглэгч маань НӨАТ авахгүй, би НӨАТ-аа нэмээд зарчихна гэдэг. Тэгэхээр би яалт ч үгүй НӨАТ-гүй хямдруулж өгөөд байгаа юм. Энэ зовлонг яаж шийдэх ёстой вэ, яавал дээр вэ? НӨАТ-аас бултсан, татвараас зугтсан гэдэг асуудалд орчих гээд байна л даа. Миний хувьд НӨАТ-ын дарамт бол байна.

5б). Жижиг бизнес. Зөөлөн оёдол болон дээл үйлдвэрлэгч: Гүний гаальтай машинтай гээд карго компаниудаар бүрдүүлэлт хийлгэдэг. Нэг контейнерт баахан жижиг зүйлүүдийг бөөнд нь хийгээд өгчихдөг. Таны, миний бүгдийн барааг хийгээд, даацын болон ерөнхий хэмжээгээр тооцоолоод гаальд тэдэн төгрөг төлнө гээд нэг тариф тогтоочихсон байдаг юм билээ. Түүнийгээ шууд хэлчихдэг. Тэгээд буцаагаад хэдэн төгрөг төлөөд байгаагаа мэдэхгүй. Бөөнд нь нэг каргонд хийчихдэг. Хэмнэлт хийх боломжгүй байдаг. Хэдэн төгрөг төлснөө мэдэхгүй, ямар бараа оруулж ирснээ мэдүүлэлгүй би дотоодод хэмнэлт яаж хийх гээд байгаа минь тодорхойгүй болчихдог.

5в). Дунд бизнес. Хүнсний үйлдвэрлэгч: Эхлээд бид юмыг ойлгохгүй эхэлж байна. Өнөөдөр анх удаагаа каргогоор юмаа оруулж ирж байна. Болдог юм байна. 6-7 жил явсны дараа энэ замыг сонгож байна. Энд нэлээн олон арга байна:

1. Бараа, үйлчилгээний төлбөрийг бага үнээр үнэлж оруулж ирнэ,
2. Тээврийн зардлаа багаар бичиж байж гааль, НӨАТ-ыг бага дүнгээр төлөх.

Гэтэл энэ байдал үйлдвэрлэгч нарын санхүүгийн тайланд бид ашигтай ажилладаг мэт харагдаад эхэлдэг. Эсрэгээрээ долоон дор юм болж байгаа юм л даа. Маш өндөр ашигтай бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн мэт харагдах гээд тэрнээсээ болоод өндөр татвар төлөх асуудалд унадаг.

5г). Бичил бизнес. Импортлогч: Гаалиар машин орж ирж байгаа. Гаалийн төлбөр төлөх болдог. Дотор нь ямар юм, юу байгаа нь тодорхойгүй. Нэг том компани наад оруулж ирж байгаа машина манай компани дээр бичээд өгвөл өг гэдэг. Тэгэхээр тэр компани гааль, НӨАТ бичүүлээд авч байгаа юм.

27 Цаад газар гэдэг нь татварын албыг хэлж байгаа.

Импортын татвар төлөөгүй орж ирсэн бараа, үйлчилгээний дараагийн борлуулалтын бүртгэлд татварын ачаалал бий болдог. Нэгэнт бараагаа гаальд мэдүүлээгүй тохиолдолд дараагийн борлуулалтыг нуух, эс бол НӨАТ-ын хэт өндөр ачаалал үүрэх, улмаар гаальд мэдүүлээгүй импортолсон барааны зардал нь орлогын албан татварын хасагдах зардлаар хүлээн зөвшөөрөгдөхгүйгээс шалтгаалж ашгийн хэмжээ хэт өндөр харагдаж, орлогын албан татвар бодит байдлаас илүү хэмжээгээр төлөх зэрэг сөрөг үр дагавар үүсгэдэг. Иймээс санхүүгийн тайлан, борлуулалт зэргээ нуухад хүрдэг байна. Түүнчлэн зарим нэг худалдааны бизнесийн хувьд бараа, ажил үйлчилгээгээ гаалийн байгууллагад мэдүүлээгүй тохиолдолд зах зээл нь хамгаалагдахгүй байх эрсдэлтэй.

Бичил бизнес эрхлэгчид “Тийм хэмжээтэй, тийм хайрцагтай юм тэдэн төгрөг шүү гээд л, каргогоор явуулчихна. Мөнгийг нь явуулаад л утасны дугаараа өгч авалцаад л, тэгээд ирчихлээ шүү аваарай гэдэг”, каргогоор бараа импортлох тохиолдолд гааль, импортын НӨАТ зэрэг татвар төлдөг эсэхээ мэддэггүй, татварын дарамт мэдэрдэггүй байна.

Энэ асуудалтай холбоотойгоор ачаа тээврийн үйлчилгээний хяналтыг сайжруулж, карго үйлчлүүлэгчийн нэр хаяг, гэрээ, контракт, бүтээгдэхүүн зэргийг цахимаар гаальд мэдүүлдэг болох шаардлагатай гэж судлаагчдын зүгээс үзэж байна.

Нэмэгдсэн өртгийн албан татвар хэрэгжүүлэлтийн дутмагшил

Фокус бүлгийн ярилцлагын явцад төрийн байгууллагын хүнд суртал, авлигаас гадна гаалийн хамгаалалт, татварын хууль, журмын тэгш бус хэрэгжилт, ил тод бус байдал түүнээс үүсэх импортын барааны чанарын асуудлууд давтан илэрч байлаа.

Шигтгээ 6 (а, б, в). НӨАТ хэрэгжүүлэлтийн дутмагшил

ба). Жижиг бизнес. Кофе шоп эрхлэгч: Би бүр гааль дээр уйлж байсан. Кофены хуурчихсан үр оруулж ирж байсан. Хүнсний урт нэртэй хуулийн дагуу энэ бол боловсруулчихсан бүтээгдэхүүн учраас надаас импортын мэдүүлэг авах ёсгүй. Гэтэл гаалийн мэргэжлийн хяналтын байцаагч надад “Энэ үрлэн кофе байна. Импортын мэдүүлгээр оруулж ирдэг, мэдүүлгээ бүрдүүлж ирээд бараагаа аваарай” гэж байгаа юм л даа. Гаалийн мөнгө, хадгалалтын мөнгө гээд явж өгдөг. Тийм болохоор би бараагаа авахаас өөр сонголтгүй. Шууд намайг “Мөнгө өг” гэж хэлээд. “Байна, надад байгаа нь энэ” гээд халаасанд байсан гучин хэдэн мянган төгрөг өгсөн чинь “Чи арай ч дээ 50 мянгыг өг” гэж хэлж байсан. Хүнд суртал. бүтээгдэхүүний чанарт нөлөөлөх гээд байдаг. Ялангуяа бяслаг зэрэг бүтээгдэхүүн маш хэцүү. Агаараар оруулж ирнэ. Солонгос энэ тэрнээс бол маш үнэтэй орж ирнэ. Хэдхэн кг оруулж ирж байгаа юмыг хуулийн дагуу дээж авна гэхээрээ талыг нь гээд аваад явчихдаг.

6б). Дунд бизнес. Хүнсний үйлдвэрлэгч: Өнөөдрийн гаалийн хяналтын сул байдал нь татвараа шударгаар төлөөд явж байгаа үйлдвэрлэл эрхлэгч нарыг бизнесээ хэвийн явуулах нөхцөлгүй, оршин тогтнох боломжгүй болгож байна. Зүгээр л бэлэн бүтээгдэхүүн каргоогоор оруулж ирээд зарах нь илүү амар байна. Каргоны компани татвараа төлж байгаа байх л даа. Гэхдээ юу байгаа нь мэдэгдэхгүй шууд базаад төлж байгааг үнэнээр төлж байгаа гэхэд эргэлзээтэй. Сандал үйлдвэрлэлээ гэж бодъё. Худалдаа эрхлэгч нар бэлэн сандлыг хамгийн бага үнээр үнэлээд импортоор оруулахад, үйлдвэрлэгч нар түүхий эдийг оруулж ирнэ, татвараа үнэнээр мэдүүлнэ, дотоодод үйлдвэрлэл явуулна, нэмүү өртөг үүсгэнэ гэхээр бодит байдал дээр импортын бэлэн бүтээгдэхүүнээс өндөр үнээр дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүн гарна. Ингээд ирэхээр бидний зах зээл шахагдаж байна шүү дээ.

Үйлдвэрлэгч нар чинь ажлын байр, тоног төхөөрөмж энэ тэр гэж олон юм ярьж явж явж байгаад үйлдвэрлэгч НӨАТ авч чадахгүй байгаа шүү дээ. Жишээлбэл бид чацаргана жимсийг энгийн хүнээс авна, НӨАТ авч чадахгүй. Бид зөгийн бал авна НӨАТ авахгүй, нэрс авна НӨАТ авахгүй. Гэтэл НӨАТ гэдэг чинь бидэнд бараг 100 хувийн татвараас ялгаагүй байна.

6в). Дунд бизнес. 4D шалавч үйлдвэрлэгч: Би гэхэд Казахстанд үйлдвэр байгуулж байсан. Казахстанд заавал ААН байхыг шаарддаг. Орж ирж байгаа бүх бараа бүртгэлтэй байдаг. Манайд каргоогоор оруулаад ирчихсэн хувь хүн ямар ч бүртгэл байдаггүй. Араас нь хөөгөөд тэдний өдөр ийм юм оруулж ирсэн байна. Үүний чинь борлуулалт хаана байна гээд хөөх газар байхгүй. Гэхдээ гаалиар оруулахдаа бусдын тусламжгүйгээр хийх боломж байхгүй. Өөрсдөө хийхээр заавал авлига нэхдэг. Тэр хүмүүс нь хийсэн нь хамаагүй дээр. Тэд танил хүрээгээ бий болгочихсон. Үйлчилгээнийхээ хөлсийг аваад зохицуулдаг.

Судалгаанд оролцогчид импортоор бараа, түүхий эд, материал, тоног төхөөрөмжийг өөрсдөө мэдүүлснээс гаалийн мэдүүлэг бүрдүүлдэг мэргэжлийн этгээдээр гүйцэтгүүлэх юм уу, карго компаниар оруулж ирэх нь чирэгдэл хамаагүй багатай гэсэн юм.

Энэ бүхнээс дүгнэхэд гаалийн болон НӨАТ-ын хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх асуудалд үүсэж буй хүндрэл буюу хуулийг харилцан өөрөөр ойлгож, тайлбарлан хэрэглэх явдал, улмаар хил, гаалийн хяналт хангалттай бус байгаагаас хамаарч импортын НӨАТ нь гарааны бизнес эрхлэгч, ЖДҮ эрхлэгч нарт гол дарамт болдог байна.

Гаалийн хууль, тогтоомжийн дагуу гаалийн хил дээр дээрх төрлийн зөрчил үүсэхэд асуудлыг хараат бусаар шийдвэрлэх тусгай бие даасан нэгж байхгүй бөгөөд энэ нь гаалийн улсын байцаагчийн бүрэн эрхийн асуудал байдаг. Харин энэ талаар гомдол гаргах бол захиргааны журмаар Захиргааны ерөнхий хуулийн дагуу холбогдох гомдлыг гаргах эрх зүйн зохицуулалттай. Гэвч, тухайн цаг хугацаанд гомдлоо хялбаршуулсан байдлаар шууд шийдвэрлүүлэх боломж нь гаалийн хууль тогтоомжид байхгүйгээс иргэд буюу бизнес эрхлэгчдийн зүгээс гаалийн хууль

тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой үүсэх хүнд суртал, үл ойлголцлыг шууд шийдвэрлүүлэх боломж дутмаг байна.

Энэхүрээнд гаалийн байгууллага дээр иргэдэд хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой хүндрэл үүсэхэд түүнд зөвлөн туслах, улмаар гаалийн байцаагчийн хууль бус аливаа шаардлагыг тухайн үед нь таслан зогсоох бие даасан хараат бус нэгж байхгүй нь эргээд импортын үйл явцыг хууль бусаар “хялбаршуулах” сонирхлыг иргэдэд төрүүлж байна.

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАР ТӨЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙН ДУТМАГШЛААС ҮҮСЭХ ҮР ДАГАВАР

Үйлдвэрлэл “нарийнтах” өвчин ба чанаргүй амьжиргаа

Өмнөх сэдэвт дурдсанчлан ЖДҮ эрхлэгч нар нь НӨАТ-аас зайлсхийх буюу татвараа төлөөгүйгээс үүсэх дутмагшил болон НӨАТ-ын хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангуулаагүйн улмаас үүсэх дутмагшил нь ЖДҮ зах зээлээс шахагдах, Монгол дахь үйлдвэрлэл “нарийнтах”-ын үндсэн шалтгаан болж, хэрэглэгч бид бүхний амьжиргааны чанарыг доройтуулдаг ажээ.

Бараа, түүхий эдийн чанарын асуудал

Судалгаанд оролцогчдын импортолж буй бараа, түүхий эддээ өгөх 0-10 онооны (маш муугаас маш сайн хүртэлх) чанарын үнэлгээ харилцан адилгүй байв. Гэхдээ маск болон гадаадад люкс зэрэглэлийн майхан үйлдвэрлэгчдээс бусад нь буюу зөөлөн оёдол, худалдаа, хүнсний үйлдвэрлэл эрхлэгчид импортоор оруулдаг бараа болон түүхий эдээ 5 ба түүнээс доош оноогоор үнэлсэн юм.

Шигтгээ 7 (а, б, в). Бараа, түүхий эдийн чанарын асуудал

7а). Дунд бизнес. Хүнсний үйлдвэрлэгч: Хүнсний бүтээгдэхүүн импортоор оруулж ирэхэд манай Монголын гаалийн болон мэргэжлийн хяналт гэдэг юм уу, хуулиараа HACCP²⁸-тай, ISO 22²⁹-той байхыг шаарддаг. Дагалдах эрүүл мэндийн шинжилгээтэй орох ёстой, гарал үүсэлтэй байх ёстой гээд олон бичиг шаарддаг. Ийм асуудал гаргахгүйн тулд байнгын үйлдвэрлэл эрхлэгч нар тухайн стандартыг хангасан үйлдвэртэй л харьцдаг. Алийг нь авах вэ, сонгох вэ гэдэг бидний асуудал байдаг.

Хүндрэлтэй асуудал юу байж болох вэ гэвэл бид жижиг улс, жижиг зах зээл дээрх жижиг компаниуд учраас түүхий эдийг их хэмжээгээр татаж чадахгүйгээс шалтгаалаад үнийн хувьд бусад том улстай харьцуулахад өндөр үнээр авдаг. Хоёрдугаарт, чанарын хувьд стандарт алдагдах магадлал өндөр. Яагаад гэвэл бид зориулалтын контейнерт ганцаараа бараа оруулж ирж чадахгүй учраас бусад бараа бүтээгдэхүүнтэй нийлүүлээд оруулж ирж байгаа. Тээвэрлэлтийн явцад тодорхой хэмжээний эрсдэл байдаг.

Бэлэн бус түүхий эд, бүтээгдэхүүн харьцангуй эрсдэл өндөртэй. Тэгэхээр импортоор оруулж ирж байгаа хүнсний түүхий эдэд гаалийн асар өндөр шалгуур тавигддаг бол импортоор оруулж ирж байгаа бэлэн бүтээгдэхүүнд гаалийн төв лаборатори огт хамааралгүй байдаг.

28 Аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналт

29 Олон улсын стандартчиллын байгууллагын хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо

7б). Дунд бизнес. 4D шалавч үйлдвэрлэгч: Түүхий эдийн чанар янз бүр орж ирдэг. Дандаа өөрчлөгдөж орж ирдэг. Нийлүүлэгч нэг хэр нь чанарын тогтсон стандарт байдаггүй. Жишээлбэл, манай шалны материал түүхий эд 5 үеэс тогтдог. Тэгээд тэр 5 үе чинь орц энэ тэр янз бүр болоод чанар хэцүү болчихдог. Манайхаас шалтгаалахгүйгээр чанар өөрчлөгдөөд байдаг. Боловсруулах үйлдвэрлэл байхгүйг хэлэх үү, хэцүү л дээ.

7в). Жижиг бизнес. Эсэг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч: Сав, баглаа, боодлоо өөрөө үйлдвэрлэдэг байвал сайхан байна. Хамгийн эцсийн шатны үйлдвэрлэлийн шатанд хэрэглэж байгаа болохоор санаа зовдог. Чанарын асуудал үнэхээр хэцүү. Чанарын тал дээр судлаачид ажиллаасай гэж боддог.

Үйлдвэрлэл “нарийнтах”

Олон улсын валютын сангийн судалгаагаар, гаалийн байгууллагын үйл ажиллагаа нь дараах хүчин зүйлсийн улмаас доголдож, татвар хураах чиг үүргээ биелүүлэхэд хүндрэлтэй байдаг гэжээ. Үүнд:³⁰

- Гадаад худалдааны болон татварын хууль тогтоомжийн ойлгомжгүй байдал нь авлига, хүнд суртлыг бий болгодог;
- Татвар, тарифын өндөр хувь хэмжээ;
- Татварын чөлөөлөлт нь бизнесийн үйл ажиллагаанд шударга бус байдлыг бий болгохоос гадна, татварын бүртгэл, тайлагналаас зайлсхийх нөхцөл болдог;
- Гаалийн мэдүүлэг гаргах, бүрдүүлэлт хийх, татвар төлөх зэрэг үйл ажиллагааны журмын ойлгомжгүй байдал болон төрийн байгууллагын хүнд суртал;
- Гаалийн хяналтын сул тогтолцоо буюу зөрчил гаргасан этгээдийг тогтоох боломж бага байх тусам уг зөрчлийг үйлдэх сонирхлыг улам нэмэгдүүлдэг;
- Үр дүнтэй хариуцлагын тогтолцоо байхгүй;
- Мэргэшсэн албан хаагчдын дутагдал.

Дээр дурдсантай манай судалгааны ихэнх үр дүн дүйж байгаа бөгөөд эдгээр хүндрэл, дутмагшил нь ЖДҮ-ийн өсөж, тэлэх боломжийг боомилдог байна. ОУВС-гийн судалгаанд заагдсан нөхцөл нь энэхүү судалгаагаар хэрхэн дүйж байгааг харуулбал, манай гаалийн байгууллагын үйл ажиллагаанд доголдол үүсчээ гэж дүгнэж болохоор байна. Үүнд:

1. Судалгаанд оролцогчдоос гаалийн бүрдүүлэлт буюу импортын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой хууль, журмын талаар хэр мэдээлэлтэй эсэх, хууль хэрэглэх явцад хэр хүндрэлтэй байсан талаар асуухад хууль, журмын мэдлэг байхгүй, хаанаас хуулиа харахаа мэдэхгүй, гаалийн

30 James T. Walsh, Practical measures to promote intergity in customs administration, International Monetary Fund, 2003, page 155. <https://www.elibrary.imf.org/display/book/9781589062115/ch11.xml>

байцаагч шууд л загнадаг, шахдаг, хүнд суртал ихтэй гэж хариулсан нь дээрх хүчин зүйлсийн 1 дэх нөхцөлтэй ижил байна.

2. Татвар, тарифын хувь, хэмжээний талаар татвар төлөгч нарын зүгээс НӨАТ-ын хувь, хэмжээ бага бөгөөд олон улстай харьцуулахад ч бага гэсэн ойлголттой байлаа. Гэхдээ дотоодын үйлдвэрлэлийг дэмжихийн тулд, уг үйлдвэрийн бүтээгдэхүүнийг дэмжих зорилгоор зарим импортын бэлэн бараанд ногдуулах татварын хэмжээг нэмээд өгвөл, үр дүнтэй талаар мэдэгдсэн. Өөрөөр хэлбэл, архи, тамхи, цементийн импортын татвар өндөр байгаа нь эргээд дотоодын үйлдвэрлэлийг дэмжиж байгаа гэдгийг хэлжээ. Энэ агуулгаар татварын хувь, хэмжээг өндөр гэсэнгүй.
3. Судалгааны үр дүнгээс харахад жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой татварын чөлөөлөлт бараг байхгүй байна. Гэхдээ, татвар төлөхгүйгээр буюу татвараас зайлсхийх замаар бараа, бүтээгдэхүүнийг импортлох тохиолдолд тухайн татвар төлөгчийн дараа, дараагийн тайланд уг барааг бүртгэхгүй байх, түүний борлуулалтыг бүртгэхгүй байх нөхцөл болж байгааг судалгааны үр дүн харуулсан. Иймээс татвараас чөлөөлөх, татварт хамруулахгүй байх асуудал нь бизнесийн бүртгэлийн гинжин холбоог тасалж байгааг илтгэж байна. Бүх этгээдийг татварт бүрэн хамруулснаар татварын тэгш, шударга байх нөхцөл хангагдах бөгөөд манайд татвар төлөхгүй байх асуудал их байгаа нь энэ зарчим алдагдаснаас гаалийн үйл ажиллагаа доголдож буйг илтгэж байна.
4. Судалгаанд оролцогчдын зүгээс гаалийн байгууллагаар явахаас илүүтэй карго компаниар дамжуулж бараа, бүтээгдэхүүнээ оруулах нь хялбар байгаа талаар мэдэгдсэн. Гааль дээр бүрдүүлэлт хийхэд гаалийн байцаагчаас тавьж байгаа шаардлага нь хууль, журмаас давсан талаар судалгаанд оролцогч хэлж байв. Мөн энэ зөрчилтэй холбоотойгоор оролцогчоос мөнгө хүртэл шаардсан талаар судалгаанд оролцогч дурдсан. Нөгөө талаас барааг оруулж ирээд бодитоор гаалиар бараагаа өөрөө мэдүүлээд явахад татварын шууд ачаалал үүсдэг ба борлуулалт хийгдээгүй байхад шууд татварын өглөг үүсэж байгаа. Бодит байдал дээр эцсийн хэрэглээ үүсээгүй байхад шууд татварын өглөгөө үүсгээд явах нь дөнгөж эхэлж байгаа гарааны бизнест маш хүндрэлтэй байдаг талаар дурдсан. Иймээс энэ төрлийн асуудалд мөн л гаалийн үйл ажиллагаанд хүндрэл үүсдэг байна гэж дүгнэж болохоор байна.
5. Судалгаанд оролцогчид гаалийн байгууллага дээрх хүнд суртлаас зайлсхийх зорилгоор каргогоор дамжуулж бараа бүтээгдэхүүнээ оруулах сонирхол байгаа нь энэ талын зөрчлийг илрүүлэх гаалийн хяналт сул байгааг илтгэж байна. Угтаа Монгол Улсын хилээр нэвтрэх бүх бараанд гаалийн болон НӨАТ ногдох учиртай. Гэсэн ч татвар ногдуулахгүйгээр барааг оруулж ирж байгаа нь энэ хэрээр гаалийн байгууллагын үйл ажиллагаа сул байгааг харуулна.

6. Гаалийн хяналтаас гадна, ийнхүү зөрчил гаргасан этгээд нь шийтгүүлсэн буюу хариуцлага тооцуулсан тохиолдол байхгүй байна. Гарааны бизнес буюу 10 хүртэлх жилийн хугацаанд гаалиар татвараа төлөхгүй орж ирсэн ч хариуцлага хүлээгээгүй явдал нь өөрөө хамгийн том зөрчил байна. Хариуцлага хүлээгээгүй бол уг зөрчлийг давтах нь тодорхой.
7. Гаалийн байгууллагын хувьд мэргэжсэн албан хаагчидтэй юу гэдэг асуудал эргэлзээтэй байна. Учир нь фокус бүлгийн ярилцлагад оролцсон бизнес эрхлэгчид бүгд хууль зөрчсөн байхад хариуцлага хүлээсэн нь үгүй. Гаалийн байцаагчаас тавьж буй шаардлага нь хүнд суртал, авлигын шинжтэй байснаас мэргэжлийн шаардлага, арга зүйн зөвлөгөө авсан бизнес эрхлэгч байсангүй.

Шигтгээ 8 (а, б, в, г). Үйлдвэрлэл “нарийнтах” асуудал

8а). Дунд бизнес. 4D шалавч үйлдвэрлэгч: Манайд байгаа асуудал гэвэл бэлэн бүтээгдэхүүн ч бай, түүхий эд ч бай урдаас ижил зардлаар орж ирдэг. Эрээнээс одоо нэг карго захихад 1м3 карго 300 юанаар орж ирж байгаа.³¹ Үйлдвэрлэл эрхэлж байгаа хүн бол өртэй, бэлэн бүтээгдэхүүн оруулж ирж байгаа хүн хадгаламжтай байх шиг байна даа. Тэгэхээр үйлдвэрлэл хөгжих ямар ч боломж байхгүй. Гаалийн хамгаалалт хэрэгтэй байна. Зах зээлийг ижил төрлийн үйлдвэрлэгч нараас хамгаалж байж л хөгжинө.

Сүүлийн 30 жилд дэлхийн өнцөг булан бүрээс хамгийн хямд барааг авч иржээ. Солонгосчууд 1960 онд аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх ажлыг хариуцлагатай эхлүүлээд гучхан жилийн дотор оргилд нь хүргэсэн. Тэгэхэд бид инфляцаас айгаад бараа, бүтээгдэхүүн оруулж ирсээр байгаад үйлдвэрлэл хөгжүүлэлгүй өдий хүрлээ. Дотоодын үйлдвэрлэл үнэтэй байна гээд байдаг, томорсон юм байхгүй байна шүү дээ. Хятадын 100, 200 жил болчихсон үйлдвэртэй Монголын 1, 2 жил болсон үйлдвэрийг өрсөлдүүлэх гээд байна шүү дээ. Ямар ч хамгаалалтгүйгээр. 18 настай хүүхдийг 3 настай хүүхэдтэй та хоёр өрсөлдөөд хоолоо олж ид гэвэл яах вэ? Бид яаж өрсөлдөх вэ?

31 Эрээн - Улаанбаатар хооронд 1м3 жижиглэн ачаа тээвэр 650 юаниар орж ирэх ханштай ч тухайн барааны овор хэмжээ, тоо ширхэгээс хамаарч тогтсон үнэ мөрдөхгүй байх нь түгээмэл тухай “Шанхай карго” компанийн ажилтан хэлж байв. <https://shankhai-cargo.mn/calculator>

8б). Дунд бизнес. Хүнсний үйлдвэрлэгч: Зарим түүхий эдийг дотоодоос авч байгаа ч ихэнхийг нь гаднаас авдаг. Гаднаас орж ирдэггүй юм гэж бараг байхгүй байх. Үйлдвэрлэл эрхлэгчид гааль, НӨАТ-ын 15.5 хувийн эсрэг нэг ёсондоо ажилладаг. Бэлэн бүтээгдэхүүн оруулж ирж зарж байгаа хүмүүс үргэлж 15.5 хувийн татвараас доогуур үнээр оруулж ирж зардаг гэсэн үг. Ингэж зовж байхаар зүгээр л бэлэн бүтээгдэхүүн оруулж ирээд зарчихвал хамаагүй амар санагддаг болсон. Би энд юм үйлдвэрлэх гээд зовж байхад тэнд нэг нөхөр зүгээр контейнерт ижил бараа оруулж ирчихээд дор хаяж татвар төлөөгүй гэж үзэхэд 15 хувийн хөнгөлөлттэй үнээр бараагаа зарах боломжийг үүсгэж байна. Нөгөө хүн чинь бараагаа хувь хүнээр оруулж ирвэл татвар энэ тэрд мэдүүлэхгүйгээр дотоодын борлуулалтын НӨАТ авахгүйгээр дахиад 10 хувь дээр хөнгөлөлт үзүүлж, улмаар гаалийн татвартай нийлээд 25 хувийн үнийн хөнгөлөлтийг амлаж, тоглоомын дүрмийг гартаа барьчихсан байна. Манайхан хэлдэг. Дотоодынх юм байж яагаад үнэтэй байна вэ гээд. 25 хувиас илүү үнийн зовлон үүрч байгаа хүн мэдээж үнэ өндөр байхгүй гээд яах билээ? Ийм байхад улс яаж ч хөгжих билээ.

8в). Жижиг бизнес. Кофе шоп эрхлэгч: АПУ-гийн Зүүнхараад үйлдвэрлэж байгаа “Хонин нуга” гээд сурталчилаад байгаа бяслаг байна шүү дээ. Монголын брэнд, гадаадын бяслагийг орлоно гээд. Гэтэл тэр “Хонин нуга” брэндийн бяслаг 1 кг нь 45-55 мянган төгрөгийн хооронд байгаа. Би тэр бяслагийг аваад сэндвич хийвэл таны өмнө байгаа сэндвич 15 мянган төгрөг л болно. 15 мянган төгрөгөөр хэн ч авахгүй. Би гаднаас импортоор орж ирж байгаа 1 кг нь 25-35 мянган төгрөгийн үнэтэй бяслагийг сонгож авах, эсвэл өөрөө хил гааль гэж зовж оруулж ирнэ. Тэгээд ингэж зовж байхаар гээд эндээс импортын бяслаг авдаг.

8г). Дунд бизнес. Угсардаг тоглоом үйлдвэрлэгч: Хэрэв экспорт гэж ярьж байгаа бол олон улсын стандартууд маш чухал. Стандартыг яаж авах вэ гэвэл үйлдвэрлэлийн процесс бүгд тэр стандартыг хангасан байх ёстой.

Одоо яагаад бид Шанхайд үйлдвэрлэл эрхлээд байна вэ гэхээр тэр үйлдвэр тэр стандартыг хангачихсан байна. Бид хүссэн хүсээгүй дэлхийд гарья гэвэл тэр стандартыг хангасан үйлдвэртэй хамтрахаас өөр замгүй байна. Бид Хятадад мөнгө төлөөд хийлгэх сонирхолтойдоо биш дэлхийд гарахын тулд ийм сонголт хийж байгаа.

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ДАРАМТЫГ ХӨНГӨРҮҮЛЭХ ЗАРИМ ШИЙДЭЛ

Олон улсад ямар нэг дэмжлэг авсан гарааны бизнес эрхлэгчдийн 69 хувь нь 2 жилийн дараа, 51 хувь нь 5 жилийн дараа, 34 хувь нь 10 жилийн дараа, 25 хувь нь 15 жилийн дараа ч үйл ажиллагаагаа явуулсаар байдгийг тогтоожээ.³²

НӨАТ-ын дэмжлэг үзүүлэхийн учир нь ажиллах хүчний болон үйлдвэрлэлийн цар хүрээгээр цомхон, бүтээмж өндөртэй, үйлдвэрлэлийн уян хатан технологитой, зах зээлд өрсөлдөх чадвар бүхий ЖДҮ, тэр дундаа гарааны бизнесийг хөгжүүлэх явдал юм. Учир нь гарааны бизнес хэрэглэгчдэдээ танигдаж амжаагүйн дээр хязгаарлагдмал мөнгөн урсгалтай байдаг тул бойжихоосоо өмнө үйл ажиллагаа нь мухардалд орох эрсдэлтэй байдаг.

Импортын НӨАТ нь ачаалал, хүндрэл үүсгэдэг эсэх талаарх асуултад, ЖДҮ эрхлэгч нар шууд татвар төлөх асуудал хүндрэлтэй болохоос хувь хэмжээ нь өндөр биш гэж байв. Харин дотоодын үйлдвэрээс хангах боломжтой зарим нэг үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнтэй ижил барааны импортын татварын хувь хэмжээг өндөр болгож, дотоодын үйлдвэрийг хамгаалах нь зүйтэй, “Ямар нэг салбарыг дэмжье гэвэл дотоодын цементийн үйлдвэрлэлийг тарифын бодлогоор дэмжиж байгаа шиг дэмжих хэрэгтэй” гэсэн санал дэвшүүлсэнтэй судлаачид санал нэг байна.

Монгол Улс ЖДҮ-ийг дэмжих бодлого баримтлах бол энэхүү салбараа тодорхойлж, ижил төстэй импортын зах зээлийг тарифын болон тарифын бус зохицуулалтаар хязгаарлах асуудлаа тавих нь зүйтэй байна. Өөрөөр хэлбэл, үйлдвэрлэлтэй өрсөлдөх бүтээгдэхүүний импортыг хязгаарлах, үйлдвэрлэлд шаардлагатай түүхий эдийн импортод татварын дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байна. Нөгөө талаар дотоодын үйлдвэрлэлийг чанаржуулахын тулд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ангилал, стандарт, кодыг дотоодын бараа, үйлчилгээндээ нэвтрүүлснээр Монголын бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд гаргахад хялбар болно.

Шигтгээ 9. Зарим шийдэл

Дунд бизнес. Хүнсний үйлдвэрлэгч: Манайх цементийн зах зээлийг хамгаалж чадсан. Том санхүүжилт хийгээд зах зээлээ хамгаалж чадсан. Өндөр татвартай, онцгой албан татвартай болчихоор Хятадаас оруулж ирж байснаас Монголдоо үйлдвэрлэх нь ашигтай тогтолцоо руу оруулсан. Үндсэндээ үндэсний 4 үйлдвэр байгаа шүү дээ. Тэд зах зээлийн жамаар хоорондоо өрсөлдөөд үнэ бууж байна. Энэ үйлдвэрлэлийг дагаад бусад бизнес, тээвэр логистик өөр бизнес ажлын байр бий болж байна. Зах зээлийн жамаар дараа нь жилд 150-200 сая долларыг цементэд зардаг байсан бол тэр долларыг Монголдоо үлдээж чадаж байна. Ийм байдлаар бид гадагшаа гарч байгаа мөнгөний урсгалыг багасгаж болох юм. Гадагшаа 10 доллар гарах байсан бол 5 юм уу, 6 нь гараг л дээ. Энэ өөрөө асар том дэмжлэг.

32 Katz Jerome A., Green Richard P (2018) Entrepreneurial small business. Fifth edition, New York, McGraw-Hill Education

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны хүрээнд жижиг, дунд үйлдвэрлэлийн салбар дахь гарааны бизнест ногдуулж буй импортын НӨАТ-ын өнөөгийн байдал, боловсронгуй болгох боломж, хэрэгцээг тодорхойлох зорилгоор бид НӨАТ төлөгчөөр бүртгэх босгыг тодорхойлж, жижиг, дунд үйлдвэрлэл дэх нэмэгдсэн өртгийн албан татвар ба импортын нэмэгдсэн өртгийн албан татварын ачаалал болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга замын талаар хөндөж судаллаа. Судалгааг Үндэсний статистикийн хорооны тоон мэдээлэл, Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжид эрх зүйн байх ёстой хэм хэмжээ буюу позитив онолын эмперик болон логик арга зүйгээр хийсэн дүн шинжилгээ, хоёр удаагийн фокус бүлгийн ярилцлагын мэдээллийн шинжилгээнд суурилан гүйцэтгэлээ. Энэхүү судалгааны үр дүнд жижиг, дунд үйлдвэрлэлийн салбар дахь гарааны бизнес эрхлэгчийн зүгээс үйлдвэрлэл эрхлэхтэй холбоотойгоор бараа, бүтээгдэхүүн импортлох үед түүнд тулгамддаг асуудлыг тодруулах, үүнээс уг үйлдвэрлэгчийн төлөх импортын НӨАТ-ын ачааллыг тооцоолох, түүнийг сайжруулах асуудлаар дараах дүгнэлтийг судлаачдын зүгээс гаргаж байна. Үүнд:

1. НӨАТ төлөгчийн 50 сая төгрөгийн босго нь бичил бизнест ачаалал үүсгэдэггүй, харин жижиг, дунд бизнесийн хувьд зохистой хэмжээнээс 4 дахин доогуур байна.
2. Импорттой холбоотой, ялангуяа карго, буюу гүний гаальтай машинаар бараа, бүтээгдэхүүн тээвэрлэх үед мэдүүлгийг үнэн зөвөөр өгдөггүй зөрчил их байна. Үүний учир нь гааль, хуулийн байгууллагын хяналт хангалтгүй, зөрчил гаргасан гаалийн ажилтан ба иргэдэд тооцох хариуцлагын механизм сул байгаатай холбоотой. Үүний уршгаар татварын тайлан зөрүүтэй гардаг, улмаар далд эдийн засаг бий болдог байна.
3. ЖДҮ-ийг төрөөс дэмжих бодлого бодитоор хэрэгждэггүй. Үүний шалтгаан нь:
 - үйлдвэрлэлийн шатлал бүр дэх стандарт хангалтгүй,
 - ЖДҮ-ийн дотоодын зах зээл тарифын бодлогоор хамгаалагдаагүй,
 - Тэдний үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийг бус, ижил төстэй бүтээгдэхүүнийх нь импортыг дэмждэгтэй холбоотой байна.
4. НӨАТ-ын хувь, хэмжээ нь биш, түүнийг мэдүүлж, тайлагнах үйл явц дахь зөрчил будилаан, төрийн оновчгүй бодлого ЖДҮ-д дарамт болж байна. Үүний улмаас тэдний өсөлт удаашрах, зогсох, өсөлтөө гүйцсэн нэг нь дотоодыг хөгжүүлэх биш гадаадад шилжин суурьших хандлагатай байна. Тухайлбал, НӨАТ-ыг ногдуулахдаа аккруэл болон мөнгөн сууриар ногдуулж байгаа нь ЖДҮ эрхлэгч нарын хувьд мөнгөн хөрөнгийн дарамтад ордог байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Судалгааны дээрх үр дүнд үндэслэн бодлого боловсруулагчдад хандан дараах санал, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- НӨАТ-ын босгыг жижиг бизнес эрхлэгчийн хамгийн доод борлуулалтын орлогын хэмжээгээр буюу 210-300 сая төгрөгийн хооронд тогтоох;
- ЖДҮ эрхлэгч нарын НӨАТ-ын ногдуулалт, тайлагналыг хялбаршуулж, мөнгөн сууриар төлдөг болох эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- НӨАТ-ын хувь, хэмжээг хэвээр хадгалах;
- Гаалийн бүрдүүлэлтийг хялбаршуулах, ЖДҮ эрхлэгч нарт зориулсан мэдээллийг ойлгомжтой, ил тод, хүртээмжтэй болгох;
- Ачаа тээврийн үйл ажиллагааг бүртгэх, түүнтэй гэрээ байгуулсан этгээдийн нэрс болон оруулж ирж буй бараа, бүтээгдэхүүнээр мэдүүлэх хялбаршуулсан тогтолцоог бий болгох, мэдүүлэгч бүрийн нэр дээр төлбөрийн баримтыг үүсгэх;
- Татварын нэгдсэн мэдээллийн сан болон гаалийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл харилцан солилцох нөхцөлийг бүрдүүлж, бараа, ажил, үйлчилгээг бүртгэх олон улсын стандартын шаардлага хангасан зураасан кодыг нэвтрүүлэх;
- Бүрдүүлэлтийн хяналт, хариуцлагыг чангатгах;
- ЖДҮ-ийн тухай хууль, журмыг сайжруулж, үйлдвэрлэлийг дэмжих асуудлыг бодлогоор дэмжих. ЖДҮ эрхлэгчийн дотоодын зах зээлийг тарифын ба тарифын бус бодлогоор хамгаалах зэрэг болно.

НОМ ЗҮЙ

Монгол эх сурвалж:

- Салбарт мөрдөгдөж буй хууль, бодлогын баримт бичиг
- А.Даваасүрэн нар, Гадаад худалдаан дахь тарифын болон тарифын бус зохицуулалт, Монгол Улсын Шинжлэх ухааны академи, Олон улс судлалын хүрээлэн, Улаанбаатар, 2022 он
- Б.Баярмаа, Б.Саранчимэг, Эдийн засгийн хөгжилд жижиг, дунд үйлдвэрлэлийн оруулж буй хувь нэмэр, ҮСХ, Улаанбаатар, 2022 он
- Б.Лхагважав нар, Татварын онол, оновчлол загварчлал, Улаанбаатар. 2020 он
- А.Золзаяа, НӨАТ-ын удирдлагын зардлыг тооцох нь, Улаанбаатар. 2021 он
- Б.Лхам-Эрдэнэ, Аж ахуйн нэгжүүдийн орлого, зардлын тайлагналд НӨАТ-ын шинэчлэлийн үзүүлсэн нөлөө, Улаанбаатар, 2021 он
- Б.Лхагважав, НӨАТ-ын шинэчлэлд суурилан татварын орлогын бүтцийг оновчлох зарим асуудал, Улаанбаатар., 2019 он
- З.Энхболд, НӨАТ-ын системийг боловсронгуй болгох арга зам, Улаанбаатар, 2019 он
- Б.Өнөрмөнх, НӨАТ төлөлт, хяналтад дашбоард арга хэрэгсэл ашиглах боломж, Улаанбаатар, 2017 он
- П.Пунцаг, НӨАТ-ын бүртгэл, тайлагналыг сайжруулах нь, Улаанбаатар, 2014 он
- Б.Болор, НӨАТ-ын хяналтыг банкны төлбөрийн системээр дэмжих боломж, Улаанбаатар
- Татварын ерөнхий газрын статистик мэдээ, баримт
- Үндэсний статистикийн хороо, Эдийн засгийн хөгжилд жижиг дунд үйлдвэрлэлийн оруулж буй хувь нэмэр, 2021 он
- Үндэсний статистикийн хороо 2022, ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, улирал, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажиллагчдын тооны бүлгээр
- Үндэсний статистикийн хороо 2022, ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД, ажиллагчдын тооны бүлэг, борлуулалтын орлогын бүлгээр
- Үндэсний статистикийн хороо 2022, ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар
- Үндэсний статистикийн хороо, 2022, МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО, нэр төрлийн ангиллаар, жилээр
- Үндэсний статистикийн хороо, 2022, ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, үйлдвэрлэлийн аргаар, салбараар

НОМ ЗҮЙ

Гадаад эх сурвалж:

- Steve Blank and Bob Dorf, The Startup Owner's Manual, TM 2012 https://smportal.unescwa.org/sites/default/files/2019-12/The_Startup_Owner%20s_Manual-A%20step%20by%20step%20guide%20for%20building%20a%20great%20company.pdf
- <https://www.theguardian.com/small-business-network/2015/jul/23/why-startups-succeed-others-dont-businesses-survive>
- Aswath Damodaran, Valuing Young, Start-up and Growth Companies: Estimation Issues and Valuation Challenges, NY., 2009 <https://pages.stern.nyu.edu/~adamodar/pdfiles/papers/younggrowth.pdf>
- Flavino Calvino, Chiara Criscuolo and Carlo Menon, Cross-country evidence on start-up dynamics, OECD, PR., 2015 <https://www.oecd.org/economy/growth/Cross-country-evidence-on-start-up-dynamics.pdf>
- Mary Jane Byrd, Small Business Management An Entrepreneur's Guidebook, 8th edition, McGraw-Hill, NY., 2017
- Michael Keena, Jack Mintz, The optimal threshold for a value-added tax, Journal of Public Economics 88, 2004
- ILO, Small Matters, GE., 2019 https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---dgreports/---dcomm/---publ/documents/publication/wcms_723282.pdf
- OECD, Entrepreneurship at a Glance, PR., 2017 [entrepreneur_aag-2017-en.pdf](https://www.oecd-ilibrary.org/entrepreneur_aag-2017-en.pdf) (oecd-ilibrary.org)
- Liam Ebrill et al., The Modern VAT, International Monetary Fund, Washington, D.C., 2001
- Worldwide VAT, GST and Sales Tax Guide 2023 | EY – Global, https://www.ey.com/en_gl/tax-guides/worldwide-vat-gst-and-sales-tax-guide
- James T. Walsh, Practical measures to promote intergity in customs administration, International Monetary Fund, 2003
- <https://www.elibrary.imf.org/display/book/9781589062115/ch11.xml>
- Katz Jerome A., Green Richard P (2018) Entrepreneurial small business. Fifth edition, New York, McGraw-Hill Education

ХАВСРАЛТ А. ФОКУС БҮЛГИЙН УУЛЗАЛТАД ОРОЛЦОГЧИЙН БҮРТГЭЛ, АСУУЛТ

Таны өгсөн мэдээллийг, нэрийг тань задруулалгүй зөвхөн судалгааны зорилгоор ашиглах тул нээлттэй хариулж, ЖДҮ эрхлэгчдийг дэмжих бидний ажилд тусална уу.

| Таны нэр | | | №: |
|---|---|---|---|
| Албан тушаал | <input type="checkbox"/> Эзэмшигч <input type="checkbox"/> Менежер | <input type="checkbox"/> Бусад, тодорхой бичнэ үү | |
| Хүйс | Эмэгтэй | <input type="checkbox"/> Эрэгтэй | <input type="checkbox"/> Бусад |
| Холбоо барих | Гар утас: | Имэйл хаяг: | |
| Байгууллагын нэр | | | |
| Хуулийн этгээдийн хэлбэр | <input type="checkbox"/> Хуулийн этгээд биш <input type="checkbox"/> ХХК | <input type="checkbox"/> ХК <input type="checkbox"/> Нөхөрлөл | <input type="checkbox"/> Хоршоо <input type="checkbox"/> Сан |
| Бизнесийн үйл ажиллагааг хэдэн оноос эхлэн явуулж эхэлсэн бэ? | | Хуулийн этгээдээр хэдэн онд бүртгүүлсэн бэ? | |
| Нийт ажилчдын тоо | <input type="checkbox"/> 1-4 <input type="checkbox"/> 5-9 | <input type="checkbox"/> 10-19 <input type="checkbox"/> 20-50 | <input type="checkbox"/> 50-200 <input type="checkbox"/> 200 дээш |
| Нэг жилийн борлуулалтын орлого | <input type="checkbox"/> 10 сая төгрөг хүртэл <input type="checkbox"/> 10.1-100 сая төгрөг | <input type="checkbox"/> 100-300 сая төгрөг <input type="checkbox"/> 300 саяас 1 тэрбум төгрөг | <input type="checkbox"/> 1 - 2.5 тэрбум төгрөг <input type="checkbox"/> 2.5 тэрбумаас дээш |
| Эдийн засгийн аль салбарт үйл ажиллагаа явуулдаг вэ? | <input type="checkbox"/> Барилга <input type="checkbox"/> Бөөний болон жижиглэн худалдаа <input type="checkbox"/> Урлаг, үзвэр, тоглоом | <input type="checkbox"/> Хүний эрүүл мэнд <input type="checkbox"/> Хөдөө аж ахуй <input type="checkbox"/> Зочид буудал, нийтийн хоол <input type="checkbox"/> Уул уурхай | <input type="checkbox"/> Тээвэр ба агуулах <input type="checkbox"/> Бусад, тодорхой бичнэ ҮҮ |
| Жилд хэдэн удаа импортоор бараа, түүхий эд, материал оруулж ирж байна вэ? | | Аль улсаас импортоор бараа оруулж ирдэг вэ? | |
| Хуулийн этгээд болохоос өмнө бараа, түүхий эд, материал импортолдог байв уу? | <input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй | Хуулийн этгээд болсноор импортоор бараа, түүхий эд, материал оруулж ирэх үйл явц илүү хялбар болж чадсан уу? | <input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй |
| Импортоор бараа, түүхий эд, материал оруулахад тулгардаг хамгийн хүндрэлтэй зүйл юу вэ? | 1. 2. | | |

Хэлэлцүүлэгт хамрагдсан танд баярлалаа

ХАВСРАЛТ Б. ФОКУС БҮЛГИЙН УУЛЗАЛТАД ОРОЛЦОГЧДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

| № | Үйл ажиллагааны чиглэл | Хуулийн этгээдийн хэлбэр |
|----|--|--------------------------|
| 1 | Зөөлөн оёдол | Нөхөрлөл |
| 2 | Оёмол бүтээгдэхүүн | ХХК |
| 3 | Хүнс /стандарт сахар, арвайтай ногоон цай, “Хатан” сүүтэй цай/ | ХХК |
| 4 | Эрүүл мэнд – зөөлөн оёдол – маск үйлдвэрлэл | ХХК |
| 5 | Сүү, мах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, | ХХК |
| 6 | Зөөлөн оёдол / давуу материал | Сан |
| 7 | Үндэсний хувцас | Хоршоо |
| 8 | Зөөлөн оёдол / давуу материал | ХХК |
| 9 | Бичгийн хэрэгсэл худалдаа | ХХК |
| 10 | Мэргэжилтэн | НӨҮГ |
| 11 | Хүнс /эрүүл мэнд дархлаа дэмжсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл | ХХК |
| 12 | Бөөний болон жижиглэн худалдаа | ХХК |
| 13 | Спорт хувцас үйлдвэрлэл | ХХК |
| 14 | Гар урлал | Хувь хүн |
| 15 | Арьс арчилгаа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч | ХХК |
| 16 | Угсардаг гэр, майхан үйлдвэрлэл | ХХК |
| 17 | 4 D шалавч үйлдвэрлэл | ХХК |
| 18 | Урлаг, үзвэр, тоглоом наадам | ХХК |
| 19 | Зөөлөн оёдол | ХХК |
| 20 | Хүнсний үйлдвэрлэл | Хувь хүн |
| 21 | Эрүүл мэндийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл | ХХК |
| 22 | Мэргэжилтэн | НӨҮГ |
| 23 | Нэхмэл бүтээгдэхүүн | ХХК |
| 24 | Амка брэнд - Арьсан урлал | ХХК |
| 25 | Кофе шоп эрхлэгч | Хувь хүн |



“Би Си Ай” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.